



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 39 (468)

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- *Зэвсэгт хүчний байгуулалтыг хөгжүүлэх хөтөлбөрийг батлах тухай*

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Журам батлах тухай*

## МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

- *Далайд газрын тос тээвэрлэгч хөлөг онгоцноос далайд учруулсан хохирлын талаар хүлээх иргэний хариуцлагын тухай 1969 оны олон улсын конвенцид нэмэлт оруулах тухай 1992 оны протокол*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2006 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2006 оны аравдугаар сарын 21

№39 (468)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- |      |  |            |      |
|------|--|------------|------|
| 620. | Зэвсэгт хүчний байгуулалтыг хөгжүүлэх хөтөлбөрийг батлах тухай | Дугаар 304 | 1153 |
|------|--|------------|------|

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- |      |                    |            |      |
|------|--------------------|------------|------|
| 621. | Журам батлах тухай | Дугаар 185 | 1158 |
|------|--------------------|------------|------|

### Гурав. МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

- |      |   |  |      |
|------|---|--|------|
| 622. | Далайд газрын тос тээвэрлэгч хөлөг онгоцноос далайд учруулсан хохирлын талаар хүлээх иргэний хариуцлагын тухай 1969 оны олон улсын конвенцид нэмэлт оруулах тухай 1992 оны протокол |  | 1166 |
|------|---|--|------|

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 10 дугаар сарын 11-ний өдөр

Дугаар 304

Улаанбаатар хот

#### Зэвсэгт хүчний байгуулалтыг хөгжүүлэх хөтөлбөрийг батлах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 7 дахь хэсэг, Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн 2006 оны 14 дүгээр хуралдааны 13 дугаар зөвлөмжийг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

"Зэвсэгт хүчний байгуулалтыг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр"-ийг хавсралтын ёсоор баталсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

*Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2006 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 304 дүгээр зарлигийн хавсралт*

#### ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ БАЙГУУЛАЛТЫГ 2015 ОН ХҮРТЭЛ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

##### Нэг. Хөтөлбөрийн үндэслэл

Олон улсын болон бүс нутгийн аюулгүй байдлын шинэ нөхцөлд дэлхийн улс орнуудын батлан хамгаалах бодлого, цэргийн урлагийн онолд гарч буй зарчмын өөрчлөлт, хийгдэж буй цэргийн шинэчлэлийн нийтлэг чиг хандлага, Монгол Улсын аюулгүй байдлын орчны үнэлгээ, түүний хэтийн төлөв, зэвсэглэл техникийн өнөөгийн болон хэтийн

төлөв байдалд хийсэн үнэлгээ, цэргийн эрдэм шинжилгээний байгууллагуудын боловсруулсан эрдэм шинжилгээний даалгаврын дүгнэлт, "Цэргийн байгуулалтыг 2005 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг үндэслэн Зэвсэгт хүчний өмнө тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх нь тайван цагт болон дайны үед хуулиар хүлээлгэсэн үүргүүдийг биелүүлэх Зэвсэгт хүчний бэлтгэлийг хангах үндсэн нөхцөл байна.

Монгол Улсын Төрийн цэргийн бодлогын үндэс, Батлан хамгаалах тухай хууль тогтоомж, Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчаас өгсөн үүрэг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан Зэвсэгт хүчний шинэчлэлийн зорилт, агуулгад нийцүүлэн Зэвсэгт хүчний байгуулалтын үндсэн асуудлуудыг боловсронгуй болгон хөгжүүлэх нь энэ хөтөлбөрийг боловсруулах үндэслэл болж байна.

Зэвсэгт хүчний байгуулалтыг цаашид төгөлдөржүүлэх үндсэн зорилго, зорилтуудыг Монгол Улсын аюулгүй байдлын гадаад, дотоод орчны өөрчлөлтийн хэтийн төлөв, улс орныг Батлан хамгаалах хэрэгцээ, Зэвсэгт хүчний байгуулалтын тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх шаардлагад тулгуурлан тодорхойлов.

Зэвсэгт хүчний байгуулалтыг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр нь Зэвсэгт хүчний цаашдын тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдан хэрэгжих урт хугацааны бодлого, үйл ажиллагааны баримт бичиг мөн.

## 1.1. Зэвсэгт хүчинд тавигдаж буй оноогийн шаардлагууд:

1.1.1. Зэвсэгт хүчний үндсэн хүч нь тайван цагийн бүтэц, зохион байгуулалтаараа олон талт үүргийг бие даан гүйцэтгэх чадвартай, хөнгөн, хөдөлгөөнт, мэргэжлийн анги, салбаруудаас бүрдсэн байх;

1.1.2. Гүйцэтгэх үүрэгтээ зохицсон зэвсэглэл, техник, хэрэгглэлээр бүрэн хангагдсан байх;

1.1.3. Мэргэжлийн өндөр ур чадвар бүхий офицер, ахлагч, гэрээт цэргээр тайван цагийн орон тооны дагуу бүрэн хангагдсан байх;

1.1.4. Улс орныг батлан хамгаалах, Зэвсэгт хүчний тухай хуулиар хүлээсэн олон талт үүргийг гүйцэтгэх чадавхийг хангахуйц санхүү-адийн засгийн нөөцтэй байх.

## 1.2. Зэвсэгт хүчнийг хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудлууд:

1.2.1. НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцох, террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаа явуулах, нийтийг хамарсан байгалийн гамшиг, технологийн осол, уламжлалт бус бусад аюулын үед олон талт үүрэг гүйцэтгэх Зэвсэгт хүчний чадавхи, боломж хязгаарлагдмал байгаа;

1.2.2. Батлан хамгаалах төсөв зөвхөн хэрэглээний шинэчлэлтэй байгаагаас Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх, зэвсэглэл техникийг үе шаттайгаар шинэчлэх, чадавхийг нэмэгдүүлэх боломжгүй байгаа;

1.2.3. Зэвсэгт хүчний үндсэн зэвсэглэл, байлдааны техникийн дийлэнх нь 25-30 жил ашиглагдаж, технологийн хувьд хоцрогдож, цаашид сэргээн сайжруулах засвар үйлчилгээ хийхгүйгээр ашиглах боломж хязгаарлагдмал болсон;

1.2.4. Цэргийн сургалт, бэлтгэлийн материаллаг бааз Зэвсэгт хүчинд мэргэшсэн цэргийн мэргэжилтэн бэлтгэх шаардлагын түвшинг бүрэн хангаж чадахгүйн дээр цэргийн албан хаагчдын ахуйн хангалт, нийгмийн хамгаалал нь тэднийг албаа сэтгэл хоёрдохгүй хаах эрэлт, хэрэгцээг хараахан хангахгүй байгаа зэрэг болно.

## Хоёр. Хөтөлбөрийн үндсэн зорилго, хөгжлийн тэргүүлэх чиглэлүүд

### 2.1. Хөтөлбөрийн үндсэн зорилго

Зэвсэгт хүчнийг үндсэн чиг үүргийнхээ зэрэгцээ НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцох, террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаа явуулах, нийтийг хамарсан байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн томоохон осол, уламжлалт бус бусад аюулын үед хүмүүнлэгийн үүрэг гүйцэтгэх чадавхитай, мэргэшсэн болгон хөгжүүлэхэд хөтөлбөрийн үндсэн зорилго оршино.

Батлан хамгаалахын нөөцийн удирдлага, зохицуулалтыг өөрчлөн сайжруулах үндсэн дээр зэвсэгт хүчинд бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийх, зэвсэглэл, цэргийн техникийн шинэчлэлийг үе шаттайгаар хэрэгжүүлэх, сургалт бэлтгэлийн тогтолцоог боловсронгуй болгох, цэргийн албан хаагчдын нийгмийн хамгааллыг сайжруулах нь хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах үндэс мөн.

### 2.2. Зэвсэгт хүчний хөгжлийн тэргүүлэх чиглэлүүд:

2.2.1. Уламжлалт бус аюул заналхийллийн шинэ орчин, хуулиар хүлээлгэсэн үүргүүдэд зохицуулан зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалтыг төгөлдөржүүлэх, ялангуяа НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцох Зэвсэгт хүчний чадавхийг нэмэгдүүлэх, террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох, нийтийг хамарсан байгалийн гамшиг, технологийн осол, уламжлалт бус бусад аюулын үед хун, байгаль орчны аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх бэлтгэлийг дээшлүүлэх;

2.2.2. Батлан хамгаалах нөөцийн удирдлага, зохицуулалтыг боловсронгуй болгож Зэвсэгт хүчний зэвсэглэл, цэргийн техникийг шинэчлэх, түүний дотор тайван цагт иргэн, цэргийн нисэхийн байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар агаарын довтолгооноос хамгаалах цэргийн техникийн шинэчлэлийг эхлүүлэх;

2.2.3. Цэргийн албан хаагчдын нөхөн хангалтын тогтолцоог боловсронгуй болгох, зэргүүн ээлжинд тайван цагт Зэвсэгт хүчинд алба хаах бие бүрэлдэхүүний зохистой харьцааг шинэчлэн тогтоож, хүний нөөцийн удирдлагын бодлогыг боловсронгуй болгох, цэргийн сургалт бэлтгэл, цэргийн албан хаагчдын нийгмийн хамгааллыг сайжруулах.

**Гурав. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах үндсэн арга хэмжээ**

**3.1. Уламжлалт бус аюул заналхийллийн шинэ орчин, зувиар хүлээлгэсэн үүргүүдэд зохицуулан Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалтыг төгөлдөржүүлэх, ялангуяа НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцох Зэвсэгт хүчний чадавхийг нэмэгдүүлэх, террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох, нийтийг хамарсан байгалийн гамшиг, технологийн осол, уламжлалт бус бусад аюулын үед хүн, байгаль орчны аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх бэлтгэлийг дээшлүүлэх чиглэлээр:**

3.1.1. Зэвсэгт хүчний олон талт үүрэг гүйцэтгэх чадавхи бүхий өндөр мэргэшсэн болгон хөгжүүлэхтэй уялдуулан батлан хамгаалах болон Зэвсэгт хүчний бодлого, үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;

3.1.2. Орон нутгийн хамгаалалтыг бүрдүүлж, төлөвшүүлэхэд Зэвсэгт хүчний оролцоог нэмэгдүүлэх;

3.1.3. Бүсийн тулгуур төвүүдэд байршилтай ерөнхий зориулалтын цэргийн мотобуудлагын ангиудын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, олон талт үүрэг гүйцэтгэх чадавхийг нэмэгдүүлэх;

3.1.4. Цэргийн мэргэжлийн нэгдмэл удирдлагаар хангах дээд байгууллага болон Зэвсэгт хүчний цэргийн ангиудын штабыг олон улсын цэргийн төлөвлөлтийн штабтай хамтран ажиллах боломжтой хувилбарыг судлан туршиж, 2007 оноос эхлэн үе шаттайгаар хэрэгжүүлэх;

3.1.5. Аюулгүй байдлын шинэ орчин нөхцөл, улсын дайчилгааны төлөвлөгөөтэй уялдсан цэргийн дайчилгааны төлөвлөгөөний олон талт хувилбаруудыг шинээр боловсруулж, мөрдүүлэх;

3.1.6. Цэргийн нөөцийн хэмжээ, цувраажилтыг шинэчлэн тогтоож, төрөөс орон нутгийн хамгаалалтын талаар баримтлах бодлогод нийцүүлэн бүсийн тулгуур төвүүдэд шилжүүлэн байрлуулах, цэргийн дайчилгааны хэрэгцээт зарим төрлийн нөөцийн 70 хүртэлх хувийг улсын нөөцөд хадгалах бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлэх замаар орон нутгийн батлан хамгаалах чадавхийн үндсийг бүрдүүлэх;

3.1.7. Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг орон нутагт сургаж бэлтгэх зориулалтаар бүсийн төвүүдэд байршилтай Зэвсэгт

хүчний анги, салбарыг түшиглэн сургалтын шинэ төвийг 2007-2010 онд 3, 2010-2015 онд 3 - ыг тус тус байгуулах;

3.1.8. НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцох үүрэг зориулалт бүхий хоёр ангийг 2006-2009 онд орон тооны бие бүрэлдэхүүн, зэвсэглэл, цэргийн техникээр бүрэн хангах, 2010 оноос гуравдахь ангийг шинээр байгуулж, улмаар НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцох үндэсний цэргийн байнгын хүчнийг 2015 он гэхэд 2500 цэргийн албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулах;

3.1.9. Цэргийн цагдаагийн салбарыг 2007 онд шинээр байгуулах;

3.1.10. Зэвсэгт хүчний "Сургалтын нэгдсэн төв"-ийг "Энхийг сахиулах ажиллагааны олон улсын сургалтын төв" болгож;

3.1.11. Энхийг дэмжих ажиллагаанд оролцох цэргийн эмнэлгийн хөдөлгөөнт багийг 2007-2009 онд томилгоот цэргийн ангиудын эмнэлгийн нэгж, энхийг сахиулах ажиллагааны олон улсын сургалтын төвд дэлгэн байрлуулах зориулалттай хэзрийн цэргийн эмнэлгийг 2010-2015 онд тус тус байгуулах;

3.1.12. Хими, инженерийн болон бусад тусгай мэргэжлийн бүлэг, салбарын энхийг сахиулах ажиллагаанд оролцоулах бэлтгэлийг хангах зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх;

3.1.13. Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаа болон террорист үйлдлийн хор уршиг, хохирлыг арилгахад оролцох үүрэг бүхий тусгай томилгоот анги, салбар, нэгжийн бүтэц, зохион байгуулалтыг бэхжүүлэн хөдөлгөөнт чадварыг сайжруулж, байнгын бэлэн байдлыг хангах;

3.1.14. Цэргийн ангиудаас уламжлалт бус аюулын үед олон талт үүрэг гүйцэтгэх зориулалттай, уян хатан, хөнгөн бүтэц, зохион байгуулалт бүхий "Зориулалтат хүчин" -ийг байгуулах, томилгоожуулах зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх.

**3.2. Батлан хамгаалах нөөцийн удирдлага, зохицуулалтыг боловсронгуй болгож Зэвсэгт хүчний зэвсэглэл, цэргийн техникийг шинэчлэх, түүний дотор тайван цагт иргэн, цэргийн нисэхийн байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар агаарын довтолгооноос хамгаалах цэргийн техникийн шинэчлэлийг эхлүүлэх чиглэлээр:**

3.2.1. Батлан хамгаалахын нөөцийн удирдлага, зохицуулалтыг боловсронгуй болгох арга хэмжээний хүрээнд урт, дунд хугацааны төлөвлөлтийг боловсронгуй болгож, батлан хамгаалах төсвийн бүтцийг олон улсын жишигт ойртуулахын зэрэгцээ, НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд цэрэг, цагдаагийн албан хаагчийг оролцуулсны нөхөн төлбөр, гадаад хамтын ажиллагааны шугамтар гадаад орнуудаас батлан

хамгаалах салбарт үзүүлэх буцалтгүй тусламж, хамтран хэрэгжүүлэх хөтөлбөрийн хөрөнгө, улсын хэмжээний бүтээн байгуулалтын томоохон ажил, арга хэмжээнд Зэвсэгт хүчний бүрэлдэхүүн, техник хэрэгслийг оролцуулах, илүүдэл авто, хуягт танкийн зарим техник хэрэгслийг зах зээлд зарж борлуулснаар төвийн гадуурх орлогыг төвлөрүүлэх "Зэвсэгт хүчний хөгжлийн сан"-г бий болгох асуудлыг холбогдох дээд байгууллагаар шийдвэрлүүлж, энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтийг болон зэвсэгт хүчний цаашдын хөгжлийг хангах эдийн засгийн үндсийг бүрдүүлэх;

3.2.2. Цэрэг, иргэний нисэхийн байгууллагууд хамтран ажиллах Засгийн газрын дэд төсөл хэрэгжүүлэх, Зэвсэгт хүчний зарим төрлийн /нисдэг тэрэг, авто болон тусгай/ техник хэрэгслийг ашиглан төрийн болон аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд төлбөрт үйлчилгээ үзүүлэх, жижиг, дунд үйлдвэрлэлийг өргөжүүлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх;

3.2.3. Энхийг сахиулах ажиллагаанд оролцох чадавхитай батальон, террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох зориулалт бүхий цэргийн анги, томилгоот салбаруудын зэвсэглэл, техникийг эхний ээлжинд шинэчлэх, сайжруулах;

3.2.4. Агаарын довтолгооноос хамгаалах цэргийн техник хэрэгсэлд технологийн шинэчлэл хийх, идэвхтэй галын хэрэгслийн хүчин чадлыг нэмэгдүүлэх;

3.2.5. Цэргийн удирдлагын холбоо, мэдээллийн системийг олон улсын жишигт ойртуулан хөгжүүлэх арга хэмжээний хүрээнд Зэвсэгт хүчний анги, салбаруудыг өгөгдөл, дуу, дүрс дамжуулдаг программын удирдлагатай тоон системийн станцуудаар хангах, байнгын цахилгаан холбооны системийг тоон системийн техник, технологиор шинэчлэн, шилэн кабельжуулах дэд төслүүдийг 2007-2012 онд хэрэгжүүлэх;

3.2.6. Техникийн чанар байдлын хувьд үүрэг гүйцэтгэх боломжтой авто, хуягт танкийн техник, артиллер, зенит болон буудлагын зэвсэглэлд сэргээн сайжруулах үйлчилгээ хийж, тодорхой хугацаанд ашиглах боломжийг бүрдүүлэх;

3.2.7. Гадаадын улс орнуудын сайжруулалтын технологийг нэвтрүүлэх, давхар зориулалт бүхий жижиг үйлдвэр, авто техник оношлох лабораторийг байгуулах, засварын тоног төхөөрөмжийг шинэчлэн сайжруулах замаар зарим төрлийн байлдааны зэвсэглэл, цэргийн техникийн байлдааны боломжийг дээшлүүлэх.

3.3. Цэргийн албан хаагчдын нөхөн хангалтын тогтолцоог боловсронгуй болгох, тэргүүн ээлжинд тайван цагт Зэвсэгт хүчинд алба хаах бие бүрэлдэхүүний зохистой харьцааг шинэчлэн тогтоож, хүний нооцнин удирдлагын бодлогыг боловсронгуй болгох, цэргийн сургалт бэлтгэл, цэргийн албан хаагчдын нийгмийн хамгааллыг сайжруулах чиглэлээр:

3.3.1. Монгол Улсын иргэдэд эх оронч үзэл, хүмүүжил төлөвшүүлэх үндэсний хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх, Зэвсэгт хүчний байнгын бие бүрэлдэхүүн, хугацаат цэргийн албан хаагчидтай явуулах төр, цэргийн уламжлал, эх оронч хүмүүжлийн хичээлийн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж мөрдүүлэх;

3.3.2. Иргэнийг гэрээт цэргийн албанд элсүүлэх болон алба хаалгах журмыг шинэчлэн боловсруулж мөрдүүлэх, тэдний нийгмийн хамгааллыг сайжруулах замаар гэрээт цэргийн албыг бэхжүүлэх, ахлагч, гэрээт цэргийн албан хаагчдын тооны эзлэх хувийг үе шаттайгаар нэмэгдүүлэх;

3.3.3. Цэргийн мэргэжил олгох боловсролын стандарт, сургалтын агуулга, технологийг олон талт үүрэг гүйцэтгэх чадавх бүхий өндөр мэргэшсэн Зэвсэгт хүчний эрхлэ хэрэгцээнд нийцүүлэн боловсронгуй болгох;

3.3.4. Цэргийн сургуулиудын бүтэц, зохион байгуулалт, сургалтын агуулга, технологийг боловсронгуй болгох, сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх, бие бүрэлдэхүүний ахуй нөхцлийг сайжруулах;

3.3.5. Зэвсэгт хүчний ангиудын сургууль-дадлагын байр, танхим, хээрийн дадлагын талбайг орчин үеийн сургалтын тренажёр, бусад тоног төхөөрөмжөөр ханган, бие бүрэлдэхүүний болон дайчилгааны бэлтгэл үүрэгтний сургалтыг явуулах боломжийг нэмэгдүүлэх;

3.3.6. "Зэвсэгт хүчний гадаад хэлний сургалтын төв"-ийг бэхжүүлж, энхийг сахиулах, олон улсын бусад ажиллагаанд оролцох болон нийт бие бүрэлдэхүүнтэй англи хэлний эрчимжсэн сургалт явуулдаг тогтолцоог бүрдүүлэх;

3.3.7. Цэргийн албан хаагчдад урт хугацааны эзэл өгөх, газар эзэмших эрх олгох, барилгын материалыг хөнгөлөлттэй үнээр худалдах, байгууллагын мэдлийн орон сууц барих зэрэг аргаар 2006-2010 онд офицер, ахлагч нарын 5 хувь, 2011-2015 онд 6.5 хувийн орон сууцны асуудлыг шийдвэрлэх;

3.3.8. Цэргийн албан хаагчид, Зэвсэгт хүчинд гэрээгээр ажиллахад тэдгээрийн гэр бүлийн хүмүүст үзүүлэх халамж үйлчилгээний чанарыг сайжруулах, хөнгөлөлт үзүүлэх тусгайлан журам боловсруулан хэрэгжүүлэх, цэргийн амралт, сувилал, аялал жуулчлалын сүлжээ бий болгох.

**Дөрөв. Зэвсэгт хүчний байгуулалтыг 2015 он хүртэл хөгжүүлэх үндсэн арга хэмжээг хэрэгжүүлснээр хүрэх үр дүн**

4.1. Мотобуудлагын болон төрөл мэргэжлийн цэргийн байнгын бүрэлдэхүүнтэй анги, салбар, тусгай томилгоот салбар, нэгжүүдийн үүрэг гүйцэтгэх чадавхи дээшилж, байнгын бэлэн байдалтай салбаруудын тоо нэмэгдэнэ;

4.2. Зэвсэглэл, техникийг шинэчлэх ажлыг шат дараатайгаар хэрэгжүүлснээр энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаа, террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох зориулалт бүхий цэргийн анги, томилгоот салбаруудын зэвсэглэл, цэргийн техник үе шаттайгаар шинэчлэгдэж, чанар байдал нь дээшилнэ;

4.3. Цэргийн сургуулиудын бүтэц, зохион байгуулалт, сургалтын агуулга, технологи өндөр хөгжилтэй орнуудын цэргийн их, дээд сургуулиудын жишигт ойртож, сургалтын материаллаг бааз нь сургалт- эрдэм шинжилгээ, туршилтын ажлыг явуулах таатай орчныг бүрдүүлснээр мэргэшсэн боловсон хүчин бэлтгэх үйл ажиллагаа Зэвсэгт хүчний байгуулалтыг хөгжүүлэх бодлого, үйл ажиллагаанд нийцнэ;

4.4. Цэргийн бүх шатны удирдлагын байгууллагын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны агуулга, технологи олон улсын жишигт ойртоно;

4.5. Цэргийн албан хаагчид, Зэвсэгт хүчинд гэрээгээр ажиллагсадын нийгмийн асуудал тодорхой хэмжээгээр шийдвэрлэгдэж, офицер, ахлагч, гэрээт цэрэг цэргийн албыг амьдралын зорилгоо болгон, итгэл үнэмшилтэй алба хаах нөхцөл бүрдэнэ;

4.6. Монгол Улсын иргэдэд эх оронч үзэл, хүмүүжил төлөвшүүлэх цэгцтэй тогтолцоо бүрдэхийн зэрэгцээ Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд бие бялдар, сэтгэл зүйн өндөр тэсвэр хатуужлыг эзэмшүүлэх зорилго бүхий сургалт бэлтгэлийн үйл ажиллагаа боловсронгуй болно;

4.7. НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцох чадавхи бүхий хүчинтэй болсноор 2015 оноос эхлэн жил бүр мотобуудлагын батальон хуртэлх нэгжээр үүрэг гүйцэтгэх боломжтой болно.

## **Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тохиолдож болох эрсдэлийн төсөөлөл**

Зэвсэгт хүчний байгуулалтыг хөгжүүлэхэд шаардагдах төсөв хөрөнгийн эх үүсвэр дутагдах явдал нь хөтөлбөрийн хэрэгжилтэд нөлөөлөх гол эрсдэл байх болно.

Зөвхөн хэрэглээний шинж чанартай батлан хамгаалах арга хэмжээний өнөөгийн төсөв Зэвсэгт хүчний хөгжил, хэтийн бодлогыг тууштай хэрэгжүүлэх нөхцлийг хангах, байлдааны зэвсэглэл, цэргийн техникийг шинэчлэх, цэргийн албан хаагч, ажилтан, ажилчдын нийгмийн хамгааллыг сайжруулахтай холбоотой зорилтын

хэрэгжилтийн үр дүнг хязгаарлах магадлал өндөр байна.

## **Зургаа.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт**

### **6.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд анхаарах гол асуудлууд**

6.1.1. Тохиолдож болох эрсдэл, саад бэрхшээлийг урьдчилан судалж нарийвчлан тооцоолох, түүнээс сэргийлэх, арилгах, даван туулах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх;

6.1.2. Хөрш болон бусад улстай харилцах ухаалаг, тэнцвэртэй цэргийн гадаад хамтын ажиллагааны бодлого, чиглэлийг баримтлах;

6.1.3. Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх тухай асуудлаар олон нийтэд нээлттэй байх, тэднээс дэмжлэг авах талаар чармайж ажиллах;

6.1.4. Зэвсэгт хүчний байгуулалтыг хөгжүүлэх хөтөлбөрийг төрөөс орон нутгийн хамгаалалтын талаар баримтлах бодлого болон бүсчилсэн хөгжлийн бодлого, үйл ажиллагаатай нягт уялдуулан хэрэгжүүлэх;

6.1.5. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд материаллаг нөөцийн хүчин зүйлийг тулгуур болгохын зэрэгцээ Зэвсэгт хүчний оюуны чадавхийг оновчтой ашиглах;

6.1.6. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад болон эцсийн үр дүнг шалгах, хянах, үнэлэх үнэлгээний системийг шинээр боловсруулж мөрдөх.

### **6.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зам, хууль эрх зүйг боловсронгуй болгох асуудлууд**

6.2.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Засгийн газар, БХЯ, ЗХЖШ, цэргийн анги, байгууллагууд хүлээх үүрэг, хариуцах ажлынхаа чиглэлээр нарийвчлан боловсруулж мөрдөх;

6.2.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв, хөрөнгө оруулалтын асуудлыг нарийвчлан төсөвлөж батлуулах, санхүүжилтийг тасалдуулахгүй байх;

6.2.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, холбогдох хууль, тогтоомж, эрх зүйн акт, тушаал, шийдвэрүүдийг цаг тухайд нь боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах, батлагдан гарсан хууль, эрх зүйн баримт бичгүүдийн хэрэгжилтийг шуурхай зохион байгуулах.

### **6.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийг төлөвлөх**

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө 2 үе шаттай байна.

I шат (2006-2010 он) – Зэвсэгт хүчний байгуулалтыг хөгжүүлэх хөтөлбөрийн үндсэн



зорилго, зорилтуудыг биелүүлэх эрх зүйн болон материаллаг баазыг хангах;

II шат (2011-2015) – Зэвсэгт хүчний байгуулалтыг хөгжүүлэх хөтөлбөрийг бүрэн хэмжээгээр хэрэгжүүлж дуусгах.

Зэвсэгт хүчний байгуулалтыг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд Засгийн газрын дэд хөтөлбөр, БХЯ-ны төслүүдийг хэрэгжүүлнэ.

### 6.4. Хөтөлбөрийг санхүүжүүлэх эх үүсвэрүүд

6.4.1. Дотоодын нийт бүтээгдэхүүнд батлан хамгаалах төсвийн эзлэх хувь хэмжээг улс орны эдийн засгийн хөгжлийн төлөв, дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлттэй уялдуулан олон улсын жишигт үе шаттайгаар ойртуулах асуудлыг төр засгийн түвшинд шийдвэрлүүлэх;

6.4.2. Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн 50 хүртэлх хувийг Зэвсэгт хүчнийг хөгжүүлэхэд төвлөрүүлэх асуудлыг холбогдох дээд байгууллагаар шийдвэрлүүлэх;

6.4.3. НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд цэрэг, цагдаагийн албан хаагчийг оролцуулсны нөхөн төлбөрийг Зэвсэгт хүчний энхийг сахиулах ажиллагааны чадавхийг дэмжихэд төвлөрүүлэх;

6.4.4. Гадаад хамтын ажиллагааны шугамаар гадаад орнуудаас батлан хамгаалах салбарт үзүүлэх буцалтгүй тусламж, хамтран хэрэгжүүлэх хөтөлбөрийн хөрөнгийг Зэвсэгт хүчний хөгжлийг дэмжихэд төвлөрүүлэх;

6.4.5. БХЯ-ны хөрөнгө оруулалтыг тогтвортой нэмэгдүүлэх, технологийн хувьд хоцрогдож, загвар нь хуучирсан авто, хуягт танкийн зарим техник хэрэгслийг зах зээлд худалдан борлуулж хөрөнгө төвлөрүүлэх;

6.4.6. Улсын агаарын орон зайн аюулгүй байдлыг хангах чиглэлээр иргэний нисэхийн байгууллагатай хамтран ажиллах Засгийн газрын хөтөлбөр хэрэгжүүлж, Зэвсэгт хүчний хөгжлийг дэмжих нэмэлт хөрөнгийн эх үүсвэрийг бий болгох;

6.4.7. Улсын хэмжээний бүтээн байгуулалтын томоохон ажил, арга хэмжээнд Зэвсэгт хүчний бүрэлдэхүүн, техник хэрэгслийг оролцуулах замаар хөрөнгө төвлөрүүлэх;

6.4.8. Цэргийн эдийн засгийг хөгжүүлэх зорилгоор Зэвсэгт хүчний зарим төрлийн /нисдэг тэрэг, авто болон тусгай/ техник хэрэгслийг ашиглан төрийн болон аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд төлбөрт үйлчилгээ үзүүлэх, жижиг, дунд үйлдвэрлэлийг өргөжүүлэх.

### 6.5. Хөтөлбөрт өөрчлөлт оруулах, зохицуулалт хийх.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад тухайд нөхцөл байдлаас шалтгаалан түүнд зохицуулалт хийх шаардлага гарсан тохиолдолд Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санал болгосноор Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчтай зөвшилцөн Засгийн газраар шийдвэрлүүлнэ.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 7 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 185

Улаанбаатар хот

### Журам батлах тухай

Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай хуулийн 8.2-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

дамжуулан зээлдүүлэх журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

"Гадаадын зээлийн хөрөнгийг дотоодод

МОНГОЛ УЛСЫН

ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

САНГИЙН САЙД

Н.БАЯРТСАЙХАН

Засгийн газрын 2006 оны 185 дугаар тогтоолын хэвсрэлт

### ГАДААДЫН ЗЭЭЛИЙН ХӨРӨНГИЙГ ДОТООДОД ДАМЖУУЛАН ЗЭЭЛДҮҮЛЭХ ЖУРАМ

#### Нэг. Нийтлэг үндэслэл

гэрээний үүргийн биелэлтийг хангуулах, хяналт тавихтай холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.1. Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай хуулийн дугау өгсн улсын байгууллага, хандивлагч орноос Засгийн газрын шугамаар авсан гадаадын зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлэх болзол, нөхцөлийг тодорхойлох.

1.2. Дамжуулан зээлдүүлэх зээл нь тодорхой болзолтой, эрсдэлийг зээлдэгч хариуцах нөхцөлтэй, хугацаатай, хүүтэй, гэрээний үүргийн биелэлтийг хангуулах баталгаатай байна.

## **Хоёр. Дамжуулан эзэлдүүлэх урьдчилсан нөхцөлийг хангах**

2.1. Гадаадын зээлийн хөрөнгөөр санхүүжих төсөл хэрэгжүүлэгч гэж Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай хуулийн 3.1.5-д заасан байгууллагыг хэлнэ.

2.2. Гадаадын зээлийн хөрөнгөөр санхүүжих төслийг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлэх байгууллагатай дамжуулан эзэлдүүлэх нөхцөлийг урьдчилан тохирч, төслийн техник-эдийн засгийн үзүүлэлтүүдийн тооцоонд тусгуулах бөгөөд төсөл нь Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай хуулийн дагуу Монгол Улсын хөгжлийн стратеги, хэтийн чиглэл, улсын төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөтэй уялдсан, нийгэм, эдийн засгийн үр ашигтай, улс орны нийтлэг ашиг сонирхлыг харгалзсан, зөвлөх үйлчилгээний нийт зардал бага байхын зэрэгцээ хэрэв дотоодын санхүүжилт шаардлагатай бол энэ талаар Зээлийн хэлэлцээрт заавал тусгагдсан байна.

2.3. Гадаадын зээлийг дотоодод дамжуулан эзэлдүүлэх нөхцөлийг олон улсын байгууллага, хандивлагч оронд санал болгох, Зээлийн хэлэлцээр байгуулах бүх шатанд тусгана.

2.4. Дамжуулан эзэлдүүлэх гэрээг Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай хууль болон энэхүү журамд заасан нөхцөлийн дагуу энэ журмын 2.1-д заасан төсөл хэрэгжүүлэгч /цаашид "Зээлдэгч" гэх/-тэй байгуулна.

## **Гурав. Дамжуулан эзэлдүүлэх гэрээ байгуулах**

3.1. Сангийн яам нь Улсын Их Хурлаар соёрхон батлагдсан Зээлийн хэлэлцээр, Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай хууль болон энэхүү журамд заасан болзол, нөхцөлийн дагуу зээлийн хөрөнгийг тодорхой хугацаа, хүүтэйгээр улсын төсөвт эргэж төлөгдөх үндсэн нөхцөлтэйгээр тухайн төслийг хэрэгжүүлэгчид гэрээний үндсэн дээр дамжуулан эзэлдүүлнэ.

3.2. Дамжуулан эзэлдүүлэх гэрээг Сангийн яамны холбогдох албан тушаалтнууд эзэлдэгчтэй

байгуулж, Сангийн сайд гарын үсэг зурж, тамга, тэмдгээр баталгаажуулна.

3.3. Зээлдэгч нь тухайн Зээлийн хэлэлцээр Улсын Их Хурлаар соёрхон батлагдсаны дараа энэхүү журмын хавсралтад заасан загварын дагуу урьдчилан тохиролцсон нөхцөл болзлыг тусгасан Дамжуулан эзэлдүүлэх гэрээний төслийг 2 хувь боловсруулан гарын үсэг, тамга, тэмдгээр баталгаажуулж, зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг эргүүлэн төлөх хуваарийн хамт Сангийн яаманд албан ёсоор ирүүлнэ.

3.4. Сангийн яам нь шаардлага хангасан Дамжуулан эзэлдүүлэх гэрээний төслийг хүлээн авч, холбогдох хууль тогтоомжийн дагуу хянан хэлэлцэж, ажлын 15 хоногт багтаан эзэлдэгчтэй Дамжуулан эзэлдүүлэх гэрээг байгуулах эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

3.5. Дамжуулан эзэлдүүлэх зээлийг тухайн гадаадын зээлийг анх авсан валютаар тооцох бөгөөд эзэлдэгч нь зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг энэ журам болон гэрээнд өөрөөр заагаагүй бол анх авсан валютаар тооцож шилжүүлнэ.

3.6. Зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг төлөх үед гарах валютын ханшны зөрүүг эзэлдэгч бүрэн хариуцна.

3.7. Сангийн яам нь эзэлдэгчид дамжуулан эзэлдүүлэх зээлийг тухайн гадаадын зээлийг анх авсан валютаас бусад валютаар тооцож болно.

## **Дөрөв. Дамжуулан эзэлдүүлэх гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулах хэлбэр**

4.1. Сангийн яам нь Дамжуулан эзэлдүүлэх гэрээний үүргийн гүйцэтгэлийг дараахь хэлбэрээр хангуулна. Үүнд:

- 4.1.1. барьцаа;
- 4.1.2. батлан даалт;
- 4.1.3. анз;
- 4.1.4. дэнчин;
- 4.1.5. баталгаа;
- 4.1.6. үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх гэрээ /фидуци/;



4.1.7. Монгол Улсын Иргэний хуульд заасан бусад арга.

4.2. Зээлдэгч нь зээлийг эргүүлэн төлөх баталгаа болж өөрийн хууль ёсны өмчлөлд байгаа бусдын өмчлөлд шилжүүлж болох хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийг дамжуулан зээлдүүлэх зээлийн барьцаа болж зээлийн барьцааны гэрээг Монгол Улсын хууль тогтоомжид заасан шаардлага, хэлбэрээр Сангийн яамтай байгуулах бөгөөд уг гэрээ нь Дамжуулан зээлдүүлэх гэрээний салшгүй хэсэг болно.

4.3. Барьцааны зүйл нь гуравдагч этгээдэд давхар барьцаалагдаагүй байна. Хэрэв барьцааны зүйл нь дундын өмч бөгөөд түүнийг дундаа хамтран өмчилж байвал түүнийг хамтран эзэмшигч иргэд, хуулийн этгээдүүд нь уг эд хөрөнгийг дамжуулан зээлдүүлэх зээл, зээлийн хүүгийн төлбөрт барьцаалахыг хүлээн зөвшөөрч, энэ тухай нотолгоог бичгээр өгсөн байна.

4.4. Барьцааны зүйл нь дамжуулан зээлдүүлэх зээлийн үнийн дүнгийн 150-иас доошгүй хувьтай тэнцэх хэмжээгээр үнэлэгдсэн байна.

4.5. Зээлдэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон нөхцөлд Сангийн яам дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

а) барьцаалсан хөдлөх эд хөрөнгийг үл маргах журмаар хураан авах;

б) барьцаалсан үл хөдлөх хөрөнгийг Сангийн яамны өмчлөлд шилжүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах.

4.6. Зээлдэгч барьцааны зүйлийг эвдэж гэмтээсэн, чанар байдлыг алдагдуулсан, дутаасан нөхцөлд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэж, гарах хохирлыг бүрэн хариуцуулна.

4.7. Зээлдэгч барьцааны зүйлийн чанар байдал, үнэ ханшийг өөрийн буруугаас бууруулсан тохиолдолд Сангийн яамны нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хангаж, нэхэмжлэлийн дутуу хэсгийг өөрийн бусад хөрөнгөөр нөхөн төлнө.

4.8. Барьцааны зүйлийн үнэлгээ нь тухайн үеийн зах зээлийн үнэ, ханшид тулгуурласан, ирээдүйн мөнгөний ханшны өөрчлөлтийг тооцсон, үнэн бодитой тогтоогдсон байна.

4.9. Хэрэв зээлдэгчийн барьцааны зүйл, бусад эх үүсвэр нь зээл, түүний хүүг төлөхөд хүрэлцэхгүй тохиолдолд зээлдэгч нь гуравдагч этгээдээр зээлийн төлбөрийн батлан даалт гаргуулж болно.

4.10. Батлан даалтын гэрээг Монгол Улсын хууль тогтоомжид заасан шаардлага, хэлбэрээр байгуулах бөгөөд уг гэрээ нь Дамжуулан зээлдүүлэх гэрээний салшгүй хэсэг болно.

4.11. Батлан даагч нь санхүүгийн хувьд уг зээлийн төлбөрийг хариуцах чадвартай, харилцах дансандаа зээлдэгчийн зээл, түүний хүүг төлөхөд хүрэлцэхүйц хөрөнгийн үлдэгдэлтэй төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой (тавиас дээш хувийн төрийн өмчит) төсвийн бус байгууллага байна.

4.12. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой (50-иас дээш хувийн төрийн өмчит) хуулийн этгээдийн зээлийн хөрөнгөөр авсан эд хөрөнгө нь төрийн өмчид хамаарах бөгөөд Дамжуулан зээлдүүлэх гэрээ дуусгавар болох хүртэл тайлан тэнцэлдээ өглөг хэлбэрээр бүртгэнэ.

4.13. Зээлдэгч нь зээлийн хөрөнгөөр олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах үүрэгтэй бөгөөд эд хөрөнгийг захиран зарцуулахыг хориглоно.

4.14. Хэрэв зээлдэгч Дамжуулан зээлдүүлэх гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн буюу хэсэгчлэн биелүүлээгүй тохиолдолд Сангийн яам нь үл маргалдах журмаар зээлдэгчийн данснаас төлбөрийг гаргуулах бөгөөд энэ тохиолдолд Сангийн яам нь зээлдэгч, зээлдэгчийн харилцах дансыг байршуулагч банктэй зайлшгүй гурван талт гэрээг байгуулна.

**Тав. Дамжуулан зээлдүүлэх зээлийн үндсэн төлбөрийг хойшлуулах, зээлийг толж дуусгах хугацаа, хүүгийн хувь хэмжээ**

5.1. Дамжуулан зээлдүүлэх зээлийн үндсэн төлбөрийг хойшлуулах хугацааг Зээлийн хэлэлцээрийн хуваарьт хугацаанаас 2-оос доошгүй жилээр богино байхаар тогтооно.

5.2. Дамжуулан зээлдүүлэх зээлийг толж дуусгах хугацааг Зээлийн хэлэлцээрийн төлж



дуусгах хугацаанаас 5-аас доошгүй жилээр богино байхаар тогтооно.

5.3. Дамжуулан зээлдүүлэх зээлийн хүүгийн жилийн хувь хэмжээг Зээлийн хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол:

1. Өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажилладаг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд гадаад зээлийн хүүгийн хувь хэмжээн дээр 1,75-аас 3,0 хувь хүртэлх шимтгэлийг нэмж.

2. хувийн өмчит хуулийн этгээдэд Дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулах үеийн Лондонгийн банк хоорондын жилийн хугацаатай валютын (зээл авсан тухайн валют) хүүгийн хувь (LIBOR) дээр 4.5 хувиас дээш хувийн шимтгэлийг нэмсэнтэй тэнцүү байхаар тус тус тооцон тогтооно.

5.4. Зээлдэгчийн зээлийг ашиглаж эхэлсэн болон зээлдүүлсэнд тооцох хугацааг Дамжуулан зээлдүүлэх гэрээнд тодорхой заах бөгөөд зээлийг ашиглаж эхэлсэн өдрөөс хүүг тооцон Сангийн яаманд төлнө.

5.5. Зээлдэгч нь Дамжуулан зээлдүүлэх гэрээгээр олгосон хөрөнгийг Зээлийн хэлэлцээрт заасан төслийн зориулалтаар ашиглана.

5.6. Зээлийн хүүг тооцох нэгж хугацаа нь сар (30 хоног), жил (360 хоног) байна.

5.7. Зээлийн гэрээний хугацааг сунгасан тохиолдолд хүүгийн хувь хэмжээг өөрчлөхгүй.

### **Зургаа. Дамжуулан зээлдүүлэх зээлийн мэдээллийн сан**

6.1. Гадаадын зээлийг дотоодод дамжуулан зээлдүүлсэн зээлийн үйл ажиллагаанд хяналт тавих, зээлийн ашиглалт, төслийн хэрэгжилт, зээлийн эргэн төлөлтийг хангах зорилгоор Сангийн яам зээлийн мэдээллийн сан хөтөлнө.

6.2. Дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулснаас хойш ажлын 4 өдрийн дотор дамжуулан зээлдүүлэх тухайн зээлийн гэрээтэй холбоотой мэдээллийг Сангийн яамны мэдээллийн санд оруулна.

6.3. Дамжуулан зээлдүүлсэн зээл бүрт хувийн хэрэг нээж, уг зээлтэй холбоотой бүх материалыг хувийн хэрэгт бүрдүүлнэ.

6.4. Зээлдэгч зээлээ бүрэн төлсөн бол зээлийн хувийн хэргийг хааж, архивт шилжүүлж хадгална.

6.5. Дамжуулан зээлдүүлэх зээл болон эргэн төлөлтийн явц байдлыг тодорхойлох зорилгоор Сангийн яамны мэдээллийн санд байгаа мэдээллээр хагас, бүтэн жилээр судалгаа гаргаж, тухайн салбарын яам, агентлагт танилцуулна.

### **Долоо. Дамжуулан зээлдүүлэх зээлийн ашиглалтад тавих хяналт**

7.1. Гадаадын зээлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шаардлагатай тохиолдолд дамжуулан зээлдүүлсэн зээлийн ашиглалтын явц байдалтай газар дээр нь танилцаж болно.

7.2. Зээлдэгч дамжуулан зээлдүүлсэн зээлийн ашиглалтын явцын талаархи тайлан, танилцуулгыг хагас, бүтэн жилээр гаргаж, зээлийн шугамаар нийлүүлэгдэх тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, бараа материалын нийлүүлэлт, үлдэгдлийн мэдээ, тайланг тухай бүр Сангийн яаманд ирүүлнэ.

7.3. Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай хуулийн дагуу тухайн салбарын яам, агентлаг бүрэн эрхийнхээ хүрээнд өөрийн хариуцсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангуулж, дотоод хяналт тавьж, төслийн нэгдсэн мэдээллийг үнэн зөв гаргаж өгөх үүргийг хүлээнэ.

### **Найм. Дамжуулан зээлдүүлсэн зээлийн төлбөрийг төвлөрүүлэх, хариуцлага ногдуулах**

8.1. Зээлдэгч Дамжуулан зээлдүүлэх гэрээнд заасан хуваарийн дагуу дамжуулан зээлдүүлсэн зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг Сангийн яамны Төрийн сан, эсхүл Монгол банкн дахь Сангийн яамны дансанд төлбөр хийх өдрийн Монгол банкны албан ханшаар тооцон хугацаанд нь төлөх үүргийг хүлээнэ.

8.2. Зээлдэгч нь үндсэн болон хүүгийн төлбөр хийсэн тухай бүр Сангийн яаманд албан бичгээр мэдэгдэж улирал бүр тооцоо нийлж баталгаажуулж байх үүрэгтэй.

8.3. Өөрийгөө санхүүжүүлэх зэрчмаар ажилладаг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хувьд хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувиар алданги тооцно.

8.4. Хувийн өмчит хуулийн этгээдийн хувьд хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй бол гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 40 хүртэлх хувиар торгууль ногдуулна.

8.5. Хэрэв зээлийг өөр зориулалтаар ашигласан, зээлийн төлбөрийг Дамжуулан зээлдүүлэх гэрээнд заасан хугацаанд эргүүлэн төлөөгүй болон энэхүү журам, Зээлийн хэлэлцээр, холбогдох бусад хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд Сангийн яам зээлийг хэсэгчлэн, эсхүл бүрэн хэмжээгээр зогсоох, төсөл хэрэгжүүлэх эрхийг түдгэлзүүлэх, холбогдох албан тушаалтанд хариуцлага ногдуулах, шүүхэд нэхэмжлэл гаргах зэрэг шат дараалсан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

8.6. Зээлдэгч нь Зээлийн хэлэлцээрийн хүрээнд Сангийн яамны зөвшөөрлөөр гуравдагч этгээдтэй давхар гэрээг байгуулж болно.

8.7. Зээлдэгч гуравдагч этгээдтэй давхар зээлийн гэрээ байгуулсан эсэхээс үл хамааран Дамжуулан зээлдүүлсэн зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг гагцхүү зээлдэгч төлнө.

8.8. Зээлдэгч нь хугацаанаасаа өмнө зээлийн төлбөрийг эргүүлэн төлж болох бөгөөд энэ тохиолдолд Сангийн яам нь Дамжуулан зээлдүүлэх гэрээний эргүүлэн төлөх төлбөрийн хуваарийн дагуу тооцсон нийт үндсэн болон хүүгийн төлбөрийг өнөөгийн үнэ цэнээр тооцож, төлбөрийг төвлөрүүлнэ. Өнөөгийн үнэ цэнийг Сангийн сайдын баталсан журмын дагуу тооцно.

байлцуулан Сангийн яамтай тооцоо нийлсэн актыг хийхийн зэрэгцээ Зээлийн хэлэлцээр, Дамжуулан зээлдүүлэх гэрээгээр хүлээсэн үүргийн гүйцэтгэл, зээлийг хэрхэн ашигласан тухай тайланг Сангийн яаманд албан ёсоор ирүүлнэ.

9.2. Сангийн яам тухайн салбарын яам, агентлагтай хамтран гэрээг дүгнэж, зээлдэгч уг зээлтэй холбогдох ямар нэг өр төлбөргүй болохыг тодорхойлсон эрх бүхий байгууллагын дүгнэлт гаргаж, зээлийг хаасан тухай Сангийн яамны мэдэгдлийг зээлдэгчид хүргүүлснээр уг Дамжуулан зээлдүүлэх гэрээ дуусгавар болсон тооцно.

9.3. Зээлийн хэлэлцээрийн дагуу төсөлд зориулж хөрөнгө шилжүүлж авах Монгол Улсын эрх бүхлээр буюу хэсэгчлэн зогсох, цуцлагдах, эсхүл дуусгавар болох тохиолдолд зээлдэгчийн зээлийн хөрөнгө хүлээн авах эрх нэгэн адил цуцлагдах буюу дуусгавар болно.

9.4. Хэрэв зээлдэгч үүсгэн байгуулсан зорилтот үйл ажиллагаагаа зогсоох, татан буугдах зэрэг тохиолдолд дамжуулан зээлдүүлсэн зээлийн үндсэн өрийн төлөгдөөгүй үлдэгдэл, тухайн үед хуримтлагдсан бүх хүүг нэн даруй Сангийн яаманд төлөх үүрэгтэй.

## Арав. Бусад

10.1. Зээлдэгч нь өөрчлөн байгуулагдах тохиолдолд зээлдэгчийн Дамжуулан зээлдүүлэх гэрээгээр хүлээсэн эрх үүрэг нь ийнхүү өөрчлөн байгуулагдсаны дүнд шинээр үүссэн хуулийн этгээдэд шилжинэ.

10.2. Төрийн өмчийн эд хөрөнгийг хувьчлахдаа дамжуулан зээлдүүлсэн зээлийн өр төлбөрийг тайлан балансад зайлшгүй тусгана.

10.3. Сангийн яам, зээлдэгчийн хооронд гарсан аливаа маргаантай асуудлыг харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд хэрэв ийнхүү харилцан тохиролцож шийдвэрлэх боломжгүй бол маргааныг Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлүүлнэ.

10.4. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хариуцлага ногдуулна.

## Ес. Дамжуулан зээлдүүлэх ажиллагааг дуусгавар болгох

9.1. Зээлдэгч дамжуулан зээлдүүлэх гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг бүрэн төлж барагдуулсан бол хяналт шалгалтын эрх бүхий албан тушаалтныг

## ГАДААДЫН ЗЭЭЛИЙН ХӨРӨНГИЙГ ДОТООДОД ДАМЖУУЛАН ЗЭЭЛДҮҮЛЭХ ЖУРМЫН ХАВСРАЛТ

### БАТЛАВ. Сангийн сайд

Энэхүү гэрээг нэг талаас Сангийн яам, нөгөө талаас . . . /цаашид "Зээлдэгч" гэх/ харилцан тохиролцож, Монгол Улсын иргэний хууль, . . . . .  
 . . . оны . . . сарын . . . өдөр Улсын Их Хурлаар соёрхон батлагдсан . . . . . зээлийн хэлэлцээр болон засгийн газрын 2006 оны . . . . . тогтоолоор батлагдсан "Гадаадын зээлийн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдүүлэх журам"-ыг үндэслэн . . . оны . . . сарын . . . . .-ны өдөр байгуулав.

### Ерөнхий зүйл

(А) Монгол Улс ба . . . /цаашид " . . . " гэх/-ны хооронд . . . . . оны . . . сарын . . . -ны өдөр байгуулсан Зээлийн хэлэлцээрийн дагуу . . . нь Монгол Улсад Зээлийн хэлэлцээрт тусгагдсан нөхцөл, болзолын дагуу /үсгээр/ . . . -тай тэнцэх зээл олгохыг зөвшөөрсөн.

(Б) Засгийн газрын шугамаар авсан гадаадын зээлийг эргүүлэн төлөх дотоод эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор Сангийн яам . . . . . Зээлийн хэлэлцээрт тодорхойлсон төсөл /цаашид "Төсөл" гэнэ/-ийг хэрэгжүүлэх . . . . . байгууллагад энэхүү гэрээнд заасан нөхцөл болзолын дагуу зээлийн хөрөнгөнөөс дамжуулан зээлдүүлэнэ.

(В) Зээлийн хэлэлцээр ба "Гадаадын зээлийг дотоодод дамжуулан зээлдүүлэх журам"-д тодорхойлсон нэр томъёоны утга агуулга нь уг баримт бичгүүдэд тодорхойлсон тэрхүү утга агуулгаа энэхүү Дамжуулан зээлдүүлэх гэрээнд нэгэн адил хадгална.

Энэхүү гэрээний хавсралт нь түүний салшгүй хэсэг мөн.

### Нэгдүгээр зүйл

Дамжуулан зээлдүүлэх урьдчилсан нөхцөл

1.1 Сангийн яам нь энэхүү гэрээнд тусгагдсан нөхцөл болзолын дагуу зээлдэгчид . . . /зээлийн хэмжээ/ . . . /валютын нэр/-ийн зээлийг дамжуулан зээлдүүлнэ.

### Н.БАЯРТСАЙХАН

1.2 Сангийн яам нь Дамжуулан зээлдүүлэх гэрээг байгуулахын зэрэгцээ зээлдэгчийн Төсөл хэрэгжүүлэх зорилгоор дамжуулан зээлдүүлэх гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлэхэд Сангийн яамнаас хамаарах бүхий л үйл ажиллагааг авч хэрэгжүүлнэ.

1.3 Зээлийн ашиглалтын хугацааг зээлийн данснаас анхны гүйлгээ гаргасан өдрөөр тооцож бөгөөд зээлийн ашиглалтыг хаах эцсийн хугацаа нь . . . оны . . . сарын . . . -ны өдөр байна.

1.4 Зээлдэгчийн нэр, байнгын хаяг:

.....

### Хоёрдугаар зүйл

Төлөөлөх эрх

2.1 Сангийн яам нь Зээлийн хэлэлцээрийн дагуу . . . -тай харьцаж, Зээлийн хэлэлцээрийн хүрээнд өөрийн нэрийн өмнөөс аливаа гэрээ байгуулах, хэлцэл хийх эрх бүхий итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр зээлдэгчийг томилно.

2.2 Зээлдэгч нь энэхүү гэрээний 3.1-д заасан эрхийн хүрээнд аливаа үйл ажиллагааг явуулахдаа Сангийн яаманд урьдчилан мэдэгдэж, . . . болон зээлдэгчийн хооронд солилцсон аливаа баримт бичгийн хувийг тухай бүр нь Сангийн яаманд хүргүүлж байна.

2.3 Зээлдэгчийн . . . дахь Зээлийн данснаас татан авсан бүхий л хөрөнгийг тухайн өдөр энэхүү гэрээнд заасан нөхцөлөөр Сангийн яамнаас зээлдэгчид зээлдүүлсэнд тооцно.

### Гуравдугаар зүйл

Хүүгийн хувь болон үндсэн төлбөрийг эргүүлж төлөх нөхцөл

3.1 Зээлдэгч нь ашигласан зээлийн өрийн үлдэгдэлд жилийн . . . -тай тэнцэх . . . . . валютаар тухай бүр Сангийн яаманд төлнө.

3.2 Хүүгийн төлбөрийг хагас жил тутам буюу жил бүрийн . . . сарын . . . ба . . . сарын . . . -нд төлөх бөгөөд хүүг жилийн 360 хоногоор, сарын 30 хоногоор тооцож бодно.

3.3 Зээлдэгч нь дамжуулан зээлдүүлсэн зээлийн үндсэн төлбөрийг хойшлуулах . . . жилийг оролцуулан . . . жилийн хугацаанд төлөх бөгөөд анхны төлбөрийг . . . оноос эхлэн жил бүрийн . . . оны . . . сарын . . . ба . . . оны . . . сарын . . . өдөр энэхүү гэрээний хавсралтад заасан төлбөрийн хуваарийн дагуу Сангийн яаманд төлнө.

3.4 Зээлийн хэлэлцээрт энэхүү төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа хураамж төлөх үүргийг Монгол Улс хүлээсэн бол зээлдэгч нь төлбөрийг тухайн үеийн ханшаар Сангийн яаманд төлөх болно.

3.5 Зээлдэгч нь үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийг . . . дахь . . . нэртэй . . . тоот дансанд шилжүүлэхдээ Монголбанкнаас зарласан тухайн өдрийн ханшаар тооцох бөгөөд нягтлан бодох бүртгэлийн журмын дагуу дансны хуулгыг үндэслэн бүртгэл тооцоог хөтөлнө. Төлбөрийн даалгаврын зориулалт гэсэн хэсэгт . . . төслийн зээлийн "Үндсэн өрийн төлбөр" эсвэл "Хүүгийн төлбөр" гэж тодорхой бичсэн байна.

3.6 Зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг төлөх үед гарах валютын ханшны зөрүүг зээлдэгч бүрэн хариуцна.

## Дөрөвдүгээр зүйл

### Сангийн яамны эрх, үүрэг

4.1 Энэхүү гэрээний аливаа заалтыг харгалзахгүйгээр Зээлийн хэлэлцээрийн дагуу төсөлд зориулж хөрөнгө шилжүүлж авах Сангийн яамны эрх бүхлээр буюу хэсэгчлэн зогсох, цуцлагдах эсхүл дуусгавар болох тохиолдолд зээлдэгчийн зээлийн хөрөнгө хүлээн авах эрх нэгэн адил зогсох, цуцлагдах эсхүл дуусгавар болно.

4.2 Зээлдэгч Дамжуулан зээлдүүлэх гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн буюу хэсэгчлэн биелүүлээгүй тохиолдсд Сангийн яам нь үл маргалдах журмаар зээлдэгчийн данснаас Төлбөрийг гаргуулах эрхтэй.

4.3 Хугацаа хэтэрсэн зээлийн төлбөрийг дор дурдсан дарааллаар хасалт хийж тооцно. Үүнд:

1. . . .

2. . . .

3. . . .

4.4 Зээлдэгч зээлийг зориулалт бусаар ашигласан, зээлийн төлбөрийг Дамжуулан зээлдүүлэх гэрээнд заасан хугацаанд эргүүлэн төлөөгүй болон "Гадаадын зээлийг дотоодод дамжуулан зээлдүүлэх журам", Зээлийн хэлэлцээр, холбогдох бусад хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд зээлийг хэсэгчлэн эсвэл бүрэн хэмжээгээр зогсоох, төсөл хэрэгжүүлэх эрхийг түдгэлзүүлэх, холбогдох албан тушаалтанд хариуцлага ногдуулах, шүүхэд нэхэмжлэл гаргах зэрэг шат дараалсан арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

4.5 Зээлдэгч гуравдагч этгээдтэй дамжуулан зээлдэх давхар гэрээ байгуулсан эсэхээс үл хамааран дамжуулан зээлдүүлсэн зээлийн төлбөрийг гагцхүү зээлдэгчээр төлүүлнэ.

## Тавдугаар зүйл

### Зээлдэгчийн эрх, үүрэг

5.1 Зээлдэгч нь хариуцсан төслийг удирдлага, зохион байгуулалт, санхүү, инженер техник, байгаль орчин болон олон улсын стандартын хэм хэмжээний хүрээнд үр ашигтай хэрэгжүүлэх үүрэгтэй.

5.2 Зээлдэгч нь Дамжуулан зээлдүүлэх гэрээгээр олгосон хөрөнгийг зөвхөн Зээлийн хэлэлцээрт заасан төслийн зориулалтаар ашиглана.

5.3 Зээлийн данснаас шилжүүлсэн төлбөрийг хүлээн авах тухай бүрт жижгэнэ гарсан зардлын үндсэн баримтыг үндэслэн бүртгэл тайланд тусгана.

5.4 Зээлдэгч нь зээлийг эргүүлэн төлөх баталгаа болгож өөрийн хууль ёсны өмчлөлд байгаа . . . . . эд хөрөнгийг дамжуулан зээлдүүлэх зээлийн барьцаа бслгож байна. Барьцааны гэрээ нь Дамжуулан зээлдүүлэх гэрээний салшгүй хэсэг болно. /Зээлдэгч нь хувийн өмчит, 50-иас доош

хувийн төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд байх тохиолдолд энэ заалтыг оруулна/

5.5 Хэрэв зээлдэгч нь гуравдагч этгээдээр зээлийн төлбөрийн батлан даалт гаргуулах бол батлан даалтын гэрээг Монгол Улсын хууль тогтоомжид заасан шаардлага, хэлбэрээр Сангийн яамтай байгуулах бөгөөд уг гэрээ нь Дамжуулан зээлдүүлэх гэрээний салшгүй хэсэг болно.

5.6 Зээлдэгчийн зээлийн хөрөнгөөр авсан эд хөрөнгө нь төрийн өмчид хамаарах бөгөөд Дамжуулан зээлдүүлэх гэрээ дуусгавар болох хүртэл тайлан тэнцэлдээ өглөг хэлбэрээр бүртгэнэ.

5.7 Зээлдэгч нь зээлийн хөрөнгөөр олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах үүрэгтэй бөгөөд эд хөрөнгийг захиран зарцуулахыг хориглоно.

5.8 Зээлдэгч нь үндсэн болон хүүгийн төлбөр хийсэн тухай бүр Сангийн яаманд албан бичгээр мэдэгдэж улирал бүр тооцоо нийлж баталгаажуулах үүрэгтэй.

5.9 Хэрэв зээлдэгч үүсгэн байгуулсан зорилтот үйл ажиллагаагаа зогсоох, татан буугдах зэрэг тохиолдолд дамжуулан зээлдүүлсэн зээлийн үндсэн өрийн төлөгдөөгүй үлдэгдэл, тухайн үед хуримтлагдсан бүх хүүг нэн даруй Сангийн яаманд төлнө.

5.10 Зээлдэгч дамжуулан зээлдүүлсэн зээлийн ашиглалтын явцын талаарх тайлан танилцуулгыг хагас, бүтэн жилээр гаргаж, зээлийн шугамаар нийлүүлэгдэх тоног, төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, бараа материалыг хүлээн авсан нийлүүлэлт, үлдэгдлийн мэдээ, тайланг тухай бүр Сангийн яаманд ирүүлнэ.

### **Зургадугаар зүйл**

Маргааныг шийдвэрлэх

6.1 Сангийн яам, зээлдэгчийн хооронд гарсан аливаа маргаантай асуудлыг харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд хэрэв ийм шугамаар шийдвэрлэх боломжгүй бол маргааныг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

### **Долдугаар зүйл**

Хүчин төгөлдөр, дуусгавар болох

7.1 Энэхүү гэрээ нь оролцогч тагууд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

7.2 Сангийн яам холбогдох яам, газартай хамтран энэхүү гэрээг дүгнэж, зээлдэгч уг зээлтэй холбогдох ямар нэг өр төлбөргүй болохыг тодорхойлсон эрх бүхий байгууллагын дүгнэлт гаргаж, зээлийг хаасан тухай Сангийн яамны мэдэгдлийг зээлдэгчид хүргүүлснээр уг Дамжуулан зээлдүүлэх гэрээ дуусгавар болсонд тооцно.

7.3 Зээлдэгч нь өөрчлөн байгуулагдах тохиолдолд зээлдэгчийн Дамжуулан зээлдүүлэх гэрээгээр хүлээсэн эрх үүрэг нь ийнхүү өөрчлөн байгуулагдсаны дүнд шинээр үүссэн хуулийн этгээдэд шилжинэ.

7.4 Төрийн өмчийн эд хөрөнгийг хувьчлахдаа дамжуулан зээлдүүлсэн зээлийн өр төлбөрийг тайлан балансад зайлшгүй тусгана. Төрийн өмчит хуулийн этгээд, 50-иас дээш хувийн төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд зээлдэгч байх тохиолдолд энэ заалтыг оруулна/

### **САНГИЙН ЯАМЫГ ТӨЛӨӨЛЖ:**

ТӨРИЙН САНГИЙН  
ГАЗРЫН ДАРГА . . .

ӨРИЙН УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА . . .

ӨРИЙН УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН . . .

### **ЗЭЭЛДЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

.....

## МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

### ДАЛАЙД ГАЗРЫН ТОС ТЭЭВЭРЛЭГЧ ХӨЛӨГ ОНГОЦНООС ДАЛАЙД УЧРУУЛСАН ХОХИРЛЫН ТАЛААР ХҮЛЭЭХ ИРГЭНИЙ ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ 1969 ОНЫ ОЛОН УЛСЫН КОНВЕНЦИД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ 1992 ОНЫ ПРОТОКОЛ\*

Энэхүү протоколд оролцогч талууд,

Далайд газрын тос тээвэрлэгч хөлөг онгоцноос далайд учруулсан хохирлын талаар хүлээх иргэний хариуцлагын тухай 1969 оны олон улсын конвенц болон түүний 1984 оны протоколыг судлан үзээд;

Тус конвенцийн 1984 оны протокол үйлчлэх хүрээг боловсронгуй болгож нөхөн төлбөрийн хэмжээг нэмэгдүүлэх тухай заасан бөгөөд хүчин төгөлдөр болоогүйг тэмдэглэн;

Газрын тосоор далайд бохирдуулахад хүлээх олон улсын хариуцлага болон хохирлыг нөхөн арилгах тогтолцоо ажиллах чадвартай байх ач холбогдлыг нотолж;

1984 оны протоколыг ойрын хугацаанд хүчин төгөлдөр болгох шаардлага байгааг үхамсарлан;

Газрын тосоор далайд бохирдуулахад учруулсан хохирлын нөхөн арилгах олон улсын сан байгуулах тухай 1971 оны олон улсын конвенцид нэмэлт өөрчлөлт оруулсантай холбогдуулж тусгай заалтууд шаадлагатай байгааг хүлээн зөвшөөрч; дараах зүйлийг тохиролцов:

#### 1 дүгээр зүйл

Энэхүү протоколын заалтаар нэмэлт өөрчлөлт оруулж буй конвенц нь цаашид "Хариуцлагын тухай 1969 оны конвенц" гэж нэрлэгдэх, Далайд газрын тос тээвэрлэгч хөлөг онгоцноос далайд учруулсан хохирлын талаар хүлээх иргэний хариуцлагын тухай 1969 оны олон улсын конвенц болно. Чингэхдээ хариуцлагын тухай конвенцийн 1976 оны протоколд оролцогч улсын хувьд Хариуцлагын тухай 1969 оны конвенцид 1976 оны протоколоор оруулсан нэмэлт өөрчлөлттэй хувилбарыг тооцно.

#### 2 дугаар зүйл

Хариуцлагын тухай 1969 оны конвенцийн 1 дүгээр зүйлд дараах нэмэлт өөрчлөлтийг оруулав:

1. 1 дэх хэсэг дараах бичвэрээр солигдов:

1. "Хөлөг онгоц" гэж газрын тосыг дүүргэж ачсан, түүнийг тээвэрлэх зориулалтаар бүтээгдсэн эсхүл тохируулан өөрчилсөн аливаа усан замын хөлөг онгоц эсхүл хөвөгч төхөөрөмжийг хэлнэ. Чингэхдээ газрын тос эсхүл өөр төрлийн ачаа тээвэрлэх хүчин чадалтай хөлөг онгоцыг зөвхөн газрын тосыг дүүргэж ачсан тээвэрлэлт хийх үед эсхүл газрын тосыг дүүргэж ачсан тээвэрлэлт хийсний дараа түүний үлдэгдэл байхгүй гэдгээ нотлоогүй зорчих үед нь үүнд оруулж тооцно.

2. 5 дахь хэсэг дараах бичвэрээр солигдов:

5. "Газрын тос" гэж хөлөг онгоцны тавцан дээр эсхүл түүний бункерт ачсанаас үл хамааран болосвруулаагүй газрын тос, мазут, хүчд дизелийн түлш болон тосолгооны шингэн зэрэг тогтвортой нүүрстөрөгчийн эрдэсжсэн тослог бодисыг хэлнэ.

3. 6 дахь хэсэг дараах бичвэрээр солигдов:

6. "Бохирдлын хохирол" гэж:  
(а) хөлөг онгоцноос гадагш газрын тос хаана ч алдагдах эсхүл асгарснаас үүссэн бохирдлын алдагдал эсхүл хохирлыг хэлнэ. Чингэхдээ олох ёстой байсан орлогын нөхөн төлбөрийг тооцохгүйгээр, байгаль орчинд учруулсан хохирлын төлбөрийн хэмжээ нь нөхөн сэргээх зорилгоор авсан эсхүл авах ёстой арга хэмжээний зардлаар хязгаарлагдана.

(b) Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал болон ийм арга хэмжээнээс цаашид гарах алдагдал эсхүл хохирлыг хэлнэ.

4. 8 дахь хэсэг дараах бичвэрээр солигдов:

8. "Зөрчил" гэж бохирдлын хохирол учруулсан заавал учруулахаар заналхийлж буй ноцтой нэг буюу хоорондоо холбоотой бүлэг хэрэг гарахыг хэлнэ.

5. 9 дэх хэсэг дараах бичвэрээр солигдов:

9. "Байгууллага" гэж Далайн олон улсын байгууллагыг хэлнэ.

6. Дараах шинэ хэсгийг 9 дэх хэсгийн дараа оруулав:

10. "Хариуцлагын тухай 1969 оны конвенц" гэж Далайд газрын тос тээвэрлэгч хөлөг онгоцноос далайд учруулсан хохирлын талаар хүлээх иргэний хариуцлагын тухай 1969 оны олон улсын конвенцийг хэлнэ. Тус конвенцийн 1976 оны протоколд оролцогч улсын хувьд энэ нэр томъёо нь тус протоколоор нэмэлт өөрчлөлт оруулсан Хариуцлагын тухай 1969 оны конвенцийг заасан гэж үзнэ.

#### 3 дугаар зүйл

Хариуцлагын тухай 1969 оны конвенцийн 2 дугаар зүйл дараах бичвэрээр солигдов:

Энэхүү конвенцийг гагцхүү дараахь тохиолдолд хэрэглэнэ:

(а) бохирдлын хохирол;

(i) нутаг дэвсгэрийн далайг оруулаад хэлэлцэн тохирогч улсын нутаг дэвсгэрт учирсан бол, түүнчлэн

\* "Конвенцид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протоколд нэгдэн орсныг соёрхон батлах тухай" Монгол Улсын хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2006 оны 24 дүгээрт нийтлэгдсэн.

(ii) олон улсын эрх зүйн дагуу байгуулагдсан эдийн засгийн онцгой бүсэд, хэрэв хэлэлцэн тохирогч тал ийм бүс байгуулаагүй бол нутаг дэвсгэрийн далайгаас гадна эсхүл түүнтэй залгаа байрлах, олон улсын эрх зүйн дагуу тухайн улс тогтоосон бөгөөд нутаг дэвсгэрийн далайн өргөнийг хэмжсэн гарааны шугамнаас гадагш далайн 200 милийн доторх бүсэд учирсан бол;

(b) хохирлоос хамгаалах, багасгах зорилгоор урьдчилан сэргийлэх арга хэмжээг аль нэг газарт авч байгаа бол.

#### 4 дүгээр зүйл

Хариуцлагын тухай 1969 оны конвенцийн 3 дугаар зүйлд дараахь нэмэлт өөрчлөлт оруулав:

1. 1 дэх хэсэг дараахь бичвэрээр солигдов:

1. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд хөлөг онгоц эзэмшигч зөрчил гаргасан эсхүл бүлэг хэргээс үүдэлтэй бол анхны хэрэг гарсан үеэс эхлэн хөлөг онгоцноос учирсан бохирдлын хохиролд хариуцлага хүлээнэ.

2. 4 дэх хэсэг дараахь бичвэрээр солигдов:

4. Энэхүү конвенцид зааснаас бусад тохиолдолд хөлөг онгоц эзэмшигчээс бохирдлын хохирлыг нөхөн арилгах төлбөрийг нэхэмжлэхгүй. Энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу энэхүү конвенц эсхүл бусад үндэслэлээр дараахь этгээдээс бохирдлын хохирлыг нөхөн арилгах төлбөрийг нэхэмжлэхгүй:

(a) хөлөг онгоц эзэмшигчийн төлөөлөгч, түүний хөлсөлсөн ажилтан эсхүл багийн гишүүдээс;

(b) багийн бүрэлдхүүнд ороогүй боловч хөлөг онгоцонд ажил үүрэг гүйцэтгэж буй хөлөг онгоцны замчин эсхүл бусад этгээдээс;

(c) хөлөг онгоц түрээслэгч (хэрхэн нэрлэгдэхээс үл хамааран хөлөг онгоцны багийн гишүүдгүй дангаар нь түрээслэгчийг үүнд оруулна), хөлгийн менежер эсхүл операторчоос;

(d) хөлөг онгоц эзэмшигч зөвшөөрсний дагуу эсхүл эрх бүхий захиргааны байгууллагын шийдвэрийн дагуу аврах үйл ажиллагаа явуулж буй хэн нэгэн этгээдээс;

(e) урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж буй хэн нэгэн этгээдээс;

(f) (c), (d) ба (e) дэд хэсэгт дурдсан этгээдийн хөлсөлсөн ажилтан эсхүл төлөөлөгчөөс.

Чингэхдээ тухайн хохирол нь дээрх этгээдүүд түүнийг учруулах санаа агуулсан эсхүл учирч болзошгүй тухай мэдсэн хэдий ч болгоомжгүйгээсээ гаргасан үйлдэл эсхүл эс үйлдлийн үр дүн байх ёсгүй.

#### 5 дугаар зүйл

Хариуцлагын тухай 1969 оны конвенцийн 4 дүгээр зүйл дараахь бичвэрээр солигдов:

Хоёр буюу түүнээс дээш тооны хөлөг онгоцонд холбоотой зөрчил гарч, түүний уршгаар бохирдлын хохирол учирсан бол бүх хөлөг онгоц эзэмшигчид 3 дугаар зүйлийн дагуу хариуцлагаас чөлөөлөгдөхөөс бусад тохиолдолд ийнхүү үл хуваагдах шинж чанартай нийт хохирлын хариуцлагыг хамтран хүлээнэ.

#### 6 дугаар зүйл

Хариуцлагын тухай 1969 оны Конвенцийн 5 дугаар зүйлд дараахь нэмэлт өөрчлөлт оруулав:

1. 1 дэх хэсэг дараахь бичвэрээр солигдов:

1. Хөлөг онгоц эзэмшигч нь аливаа осолд хүлээх хариуцлагаа энэхүү конвенцид заасны дагуу дараахь байдлаар тооцоолсон нийлбэр дүнгээр хязгаарлах эрхтэй:

a. 5000 даацны нэгжээс хэтрэхгүй хөлөг онгоцонд 3 сая тооцооны нэгжээр;

b. түүнээс хэтэрсэн даацтай хөлөг онгоцны хувьд (a) дэд хэсэгт заасан дүн дээр даацын нэмэлт нэгж бүрт 420 тооцооны нэгж нэмж тооцох дүнгээр.

Чингэхдээ энэ нийлбэр дүн нь аль ч тохиолдолд 59.7 сая тооцооны нэгжээс хэтрэхгүй байна.

2. 2 дахь хэсэг дараахь бичвэрээр солигдов:

2. Хэрэв хохирол учруулах санаа агуулсан эсхүл тийм хохирол учирч болзошгүй тухай мэдсэн хэдий ч болгоомжгүйгээс гаргасан хөлөг онгоц эзэмшигчийн үйлдэл эсхүл эс үйлдлийн үр дүнд тухайн хохирол учирсан гэдэг нь батлагдвал хөлөг онгоц эзэмшигч энэхүү конвенцийн дагуу хариуцлагаа хязгаарлах эрхгүй болно.

3. 3 дахь хэсэг дараахь бичвэрээр солигдов:

3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хариуцлага хязгаарлах эрхээ эдлэхийн тулд хөлөг онгоц эзэмшигч нь 9 дүгээр зүйлийн дагуу гаргасан нэхэмжлэлийг хүлээн авсан хэлэлцэн тохиролцогч аль нэг улсын шүүх эсхүл эрх бүхий өөр байгууллагад, хэрэв нэхэмжлэл гаргаагүй бол 9 дүгээр зүйлийн дагуу хүлээн авч болзошгүй, хэлэлцэн тохиролцогч аль нэг улсын шүүх эсхүл эрх бүхий өөр байгууллагад хариуцлагын хязгаарыг илэрхийлсэн нийлбэр дүнгээр сан байгуулна. Санг данс нээх, банкны баталгаа гаргах эсхүл сан байгуулагдсан хэлэлцэн тохирогч улсын хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн, шүүх болон эрх бүхий бусад байгууллага хүлээн зөвшөөрсөн бусад төрлийн баталгаа гаргах хэлбэрээр тус тус байгуулж болно.

4. 9 дэх хэсэг дараахь бичвэрээр солигдов:



9. (а) Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан "тооцооны нэгж" нь Олон улсын валютын сангийн эзэлжих тусгай эрх болно. 3 дахь хэсгийн дагуу сан байгуулсан өдөр тухайн үндэсний мөнгөн тэмдэгт эзэлжих тусгай эрхээр илэрхийлэгдэх өртгийг үндэслэн 1 дэх хэсэгт заасан дүнг үндэсний мөнгөн тэмдэгт рүү хөрвүүлнэ. Олон улсын валютын сангийн гишүүн хэлэлцэн тохирогч улсын хувьд эзэлжих тусгай эрхээр илэрхийлэгдэх үндэсний мөнгөн тэмдэгтийн өртгийг Олон улсын валютын сан гүйлгээ болон тооцоондоо ашиглаж байгаа тухайн өдрийн үнэлгээний аргачлалын дагуу тооцоолно. Олон улсын валютын сангийн гишүүн бус хэлэлцэн тохирогч улсын хувьд эзэлжих тусгай эрхээр илэрхийлэгдэх үндэсний мөнгөн тэмдэгтийн өртгийг тухайн улсын тогтоосон аргаар тооцоолно.

9. (b) Олон улсын валютын сангийн гишүүн бус бөгөөд дотоодын хууль тогтоомж нь энэ зүйлийн 9 дэх хэсгийн (а) дэд хэсгийн заалтыг хэрэглэхийг зөвшөөрдөггүй тохиолдолд тухайн хэлэлцэн тохирогч улс энэхүү конвенцийг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, нэгдэн орох үедээ болон түүнээс хойш хэдийд ч 9 дэх хэсгийн (а) дэд хэсэгт дурдсан тооцооны нэгж 15 алтан франктай тэнцүү болохыг зарлаж болно. Энэ хэсэгт Дурьдсан алтан франк нь есөн зуугийн сорьц бүхий жаран тав аравны таван миллиграмм алтны хэмжээтэй тэнцүү байна. Алтан франкыг тухайн улсын хуулийн дагуу үндэснийх нь мөнгөн тэмдэгт рүү хөрвүүлнэ.

9. (c) 9 дэх хэсгийн (а) дэд хэсгийн сүүлийн өгүүлбэрт дурдсан тооцоолох арга болон 9 дэх хэсгийн (b) дэд хэсэгт заасан хөрвүүлэлтийг хийхдээ 9 дэх хэсгийн (а) дэд хэсгийн эхний 3 өгүүлбэрийн заалтыг хэрэглэснээр гарах, 1 дэх хэсэгт заасан нийлбэр дүнгийн бодит өртгийг хэлэлцэн тохирогч улсын үндэсний мөнгөн тэмдэгтээр аль болох бодитойгоор илэрхийлнэ. Энэхүү конвенцийг соёрхон баталсан тухай батламж жуух бичиг болон хүлээн зөвшөөрсөн, баталсан эсхүл түүнд нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулахаар хүлээлгэн өгөх үедээ хэлэлцэн тохирогч тал 9 дэх хэсгийн (а) дэд хэсэгт дурьдсан тооцоолох арга эсхүл шаардлагатай тохиолдолд 9 дэх хэсгийн (b) дэд хэсэгт заасан хөрвүүлэлтийн дүнг гэрээ хадгалагчид мэдэгдэнэ.

5. 10 дахь хэсэг дараахь бичвэрээр солигдов:

10. Энэ зүйлийн зорилгоор хөлөг онгоцны даац гэж Хөлөг онгоцны даацын хэмжүүрийн тухай 1969 оны Олон улсын конвенцийн I хавсралтад орсон даацын хэмжүүрийн журмын дагуу тооцоолсон нийт даацыг хэлнэ.

6. 11 дэх хэсгийн хоёрдугаар өгүүлбэр дараахь бичвэрээр солигдов:

Хөлөг онгоц эзэмшигч нь 2 дахь хэсгийн дагуу хариуцлагыг хязгаарлах эрхгүй байсан ч ийм сан байгуулж болох ба чингэх тохиолдолд энэ нь хөлөг онгоц эзэмшигчийн эсрэг нэхэмжлэл гаргалчийн эрхийг хөндөх өсгүй.

## 7 дугаар зүйл

Хариуцлагын тухай 1969 оны конвенцийн 7 дугаар зүйлд дараахь нэмэлт өөрчлөлтийг оруулав:

1. 2 дахь хэсгийн эхний хоёр өгүүлбэр дараахь бичвэрээр солигдов:

Энэхүү конвенцийн заалтын дагуу даатгал болон санхүүгийн бусад баталгаа хүчин төгөлдөр эсэхийг нотлож буй гэрчилгээг 1 дэх хэсэгт заасан шаардлага хангасан гэдгийг хэлэлцэн тохирогч талын холбогдох эрх бүхий байгууллага тогтоосны дараа түүнийг хөлөг онгоцонд олгоно. Хэлэлцэн тохирогч улсад бүртгүүлсэн хөлөг онгоцны хувьд гэрчилгээг нь хөлөг онгоцыг бүртгэсэн улсын холбогдох эрх бүхий байгууллага олгож эсхүл баталгаажуулна. Хэлэлцэн тохирогч улсад бүртгэгдээгүй хөлөг онгоцны хувьд гэрчилгээг нь хэлэлцэн тохирогч бэл гэрчилгээг олгосон буюу баталгаажуулсан улсын эрх бүхий байгууллагад хуулбарыг хадгалуулна.

2. 4 дэх хэсэг дараахь бичвэрээр солигдов:

4. Энэ гэрчилгээ нь хөлөг онгоцонд явах бөгөөд түүний хуулбарыг хөлөг онгоцны бүртгэлийг хөтөлж буй эрх бүхий байгууллагад хадгалуулна. Хэрэв хөлөг онгоц тухайн хэлэлцэн тохирогч улсад бүртгүүлээгүй бол гэрчилгээг олгосон буюу баталгаажуулсан улсын эрх бүхий байгууллагад хуулбарыг хадгалуулна.

3. 7 дахь хэсгийн эхний өгүүлбэр дараахь бичвэрээр солигдов:

2 дахь хэсгийн заалтын дагуу хэлэлцэн тохирогч улс өөрийн эрх хэмжээний хүрээнд олгосон эсхүл баталгаажуулсан гэрчилгээ нь энэхүү конвенцийг зорилгын дагуу хэлэлцэн тохирогч бусад улсад хүлээн зөвшөөрөгдөх бөгөөд эдгээр улсын олгосон эсхүл баталгаажуулсан гэрчилгээтэй адил хүчинтэй гэж тооцогдоно. Үүнд тухайн улсад бүртгэгдээгүй хөлөг онгоцонд олгосон эсхүл баталгаажуулсан гэрчилгээ мөн хамаарна.

4. 7 дахь хэсгийн хоёр дахь өгүүлбэрт "хөлөг онгоцыг бүртгэсэн улстай" гэснийг "гэрчилгээ олгосон эсхүл баталгаажуулсан улстай" гэдгээр солив.

5. 8 дахь хэсгийн хоёр дахь өгүүлбэрийг дараахь бичвэрээр солив.

Ийм тохиолдолд, 5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн дагуу хөлөг онгоц эзэмшигч хариуцлагаа хязгаарлах эрхгүй болсон ч, хариуцагч этгээд 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хариуцлагын хязгаарыг хэрэглэж болно.

## 8 дугаар зүйл

Хариуцлагын тухай 1969 оны конвенцийн 9 дүгээр зүйлд дараахь нэмэлт өөрчлөлтийг оруулав.

1 дэх хэсгийг дараахь бичвэрээр солив:

1. Хэрэв нутаг дэвсгэрийн далай болон 2 дугаар зүйлд дурьдсан бүсийг оруулсан

нэг буюу түүнээс дээш хэлэлцэн тохирогч улсын нутаг дэвсгэрт зөрчил гарч улмаар бохирдлын хохирол учирсан эсхүл тухайн нутаг дэвсгэрт хохирлоос хамгаалах, багасгах зорилгоор урьдчилан сэргийлэх арга хэмжээ авагдсан бол нөхөн төлбөрийн нэхэмжлэлийг зөвхөн тухайн хэлэлцэн тохирогч улс эсхүл улсуудын шүүхэд гаргаж болно. Ийм нэхэмжлэл гаргах тухай зохих мэдэгдлийг хариуцагч этгээдэд уламжилна.

## 9 дүгээр зүйл

Дараахь хоёр шинэ зүйлийг Хариуцлагын тухай 1969 оны конвенцийн 12 дугаар зүйлийн дараа нэмж оруулав:

### XII bis зүйл

#### Шилжилтийн үеийн заалт

Зөрчил гарсан үед аль нэг улс нэмэлт өөрчлөлт орсон энэхүү конвенц болон Хариуцлагын тухай 1969 оны конвенцийн аль алиных нь оролцогч тал байвал дараахь шилжилтийн үеийн заалтыг хэрэглэнэ.

(a) зөрчил гарсны улмаас энэхүү конвенцийн зохицуулах хүрээнд ордог бохирдлын хохирол учирсан бол энэхүү конвенцийн дагуу хүлээх хариуцлагыг давхар ногдуулахгүй бөгөөд Хариуцлагын тухай 1969 оны конвенцээр ногдуулах хэмжээнд чөлөөлсөн гэж тооцно;

(b) Зөрчил гарсны улмаас энэхүү конвенцийн зохицуулах хүрээнд ордог бохирдлын хохирол учирсан бөгөөд тухайн улс нь энэхүү конвенц болон Газрын тосоор далайг бохирдуулахад учирсан хохирлыг нөхөн арилгах олон улсын сан байгуулах тухай 1971 оны олон улсын конвенцийн оролцогч тал бол энэ зүйлийн (a) дэд хэсгийг хэрэглэсний дараа чөлөөлөгдсөн хариуцлага нь 1971 оны конвенцийг хэрэглэснээр нөхөн төлөгдөөгүй үлдсэн бохирдлын хохирлын хэмжээгээр энэхүү конвенцийн дагуу оногдоно;

(c) Энэхүү конвенцийн 3 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг хэрэглэхдээ "энэхүү конвенц" гэснийг тухайн нөхцөл байдлаас хамаарч энэхүү конвенц эсхүл Хариуцлагын тухай 1969 оны конвенц гэж тайлбарлана;

(d) Энэхүү конвенцийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг хэрэглэхдээ сан байгуулах нийлбэр дүнг энэ зүйлийн (a) дэд хэсгийн дагуу чөлөөлөгдсөн хариуцлагын хэмжээгээр бууруулна.

### XII ter зүйл

#### Төгсгөлийн заалт

Энэхүү конвенцийн төгсгөлийн заалт нь Хариуцлагын тухай 1969 оны конвенцид нэмэлт өөрчлөлт оруулсан 1992 оны протоколын 12-оос 18 дугаар зүйлүүд болно. Энэхүү конвенцид дурьдсан "хэлэлцэн тохирогч улс" гэсэн нь тус протоколд дурьдсан "хэлэлцэн тохирогч улс" болно.

## 10 дугаар зүйл

Хариуцлагын тухай 1969 оны конвенцийн хавсралтад орсон гэрчилгээний загвар нь энэхүү протоколын хавсралтад орсон загвараар солигдоно.

## 11 дүгээр зүйл

1. Энэхүү протоколд оролцогч талуудын хувьд Хариуцлагын тухай 1969 оны конвенц болон энэхүү протоколыг нэг баримт бичиг гэж үзэх буюу тайлбарлана.

2. Энэхүү протоколоор нэмэлт өөрчлөлт оруулсан Хариуцлагын тухай 1969 оны конвенцийн 1-ээс XII төр хүртэлх зүйлүүд болон гэрчилгээний загварыг "Далайд газрын тос тээвэрлэгч хөлөг онгоцноос далайд учруулсан хохирлын талаар хүлээх иргэний хариуцлагын тухай" 1992 оны олон улсын конвенц (Хариуцлагын тухай 1992 оны конвенц) гэж нэрлэнэ.

## ТӨГСГӨЛИЙН ЗААЛТУУД

### 12 дугаар зүйл

#### Гарын үсэг зурах, соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах болон нэгдэн орох

1. Энэхүү протокол нь 1993 оны 1-р сарын 15-ны өдрөөс эхлэн 1994 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр хүртэл гарын үсэг зурахад Лондон хотноо бүх улсад нээлттэй байна.

2. 4 дэх хэсэгт зааснаар аливаа улс дараахь байдлаар энэхүү протоколд оролцогч тал болно:

(a) соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах болзолтойгоор гарын үсэг зурж, дараа нь соёрхон батлаж, хүлээн зөвшөөрч эсхүл батласнаар; эсхүл,

(b) нэгдэн орсноор.

3. Соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах эсхүл нэгдэн орохдоо Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад албан ёсны баримт бичгийг хадгалуулахаар хүлээлгэн өгнө.

4. Цаашид "Сан байгуулах тухай 1971 оны конвенц" гэх, Газрын тосоор далайг бохирдуулахад учирсан хохирлыг нөхөн арилгах олон улсын сан байгуулах тухай 1971 оны олон улсын конвенцийн оролцогч аливаа улс тус конвенцид нэмэлт өөрчлөлт оруулсан 1992 оны протоколыг соёрхон батлаж, хүлээн зөвшөөрч, батлаж эсхүл түүнд нэгдэн орсон тохиолдолд энэхүү протоколыг соёрхон батлаж, хүлээн зөвшөөрч, батлаж эсхүл түүнд нэгдэн орж болно. Чингэхдээ өөрийнх нь хувьд энэхүү протокол хүчин төгөлдөр болох өдөр тухайн улс Сан байгуулах тухай 1971 оны конвенцийг цуцлаагүй байх ёстой.

5. Хариуцлагын тухай 1969 оны конвенцид оролцогч тал болоогүй боловч энэхүү протоколд оролцогч тал болсон аливаа улс энэхүү протоколоор нэмэлт өөрчлөлт оруулсан Хариуцлагын тухай 1969 оны конвенцийн заалтаар протоколд оролцогч улсын тухайд үүрэг хүлээж, харин Хариуцлагын тухай 1969 оны конвенцийн

заалтаар тус конвенцид оролцогч улсын тухайд үүрэг хүлээхгүй.

6. Энэхүү протоколоор нэмэлт өөрчлөлт оруулсан Хариуцлагын тухай 1969 оны конвенцид оруулах нэмэлт өөрчлөлт хүчин төгөлдөр болсны дараа хүлээлгэн өгсөн соёрхон батласан тухай батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн, батласан эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгийг нэмэлт өөрчлөлт орсон конвенцид хамааруулж үзнэ.

## 13 дугаар зүйл

### Хүчин төгөлдөр болох

1. Энэхүү протокол нь газрын тос тээвэрлэдэг нийт хөлөг онгоцны даац нь нэг сая нэгжээс доошгүй байх дөрвөн улсыг оруулсан нийт арван улс соёрхон батласан тухай батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн, батласан, нэгдэн орсон тухай баримт бичгээ Байгууллагын нарийн бичгийн даргад хадгалуулахаар хүлээлгэн өгснөөс хойш арван хоёр сарын дараа хүчин төгөлдөр болно.

2. Сан байгуулах тухай 1971 оны конвенцийн хэлэлцэн тохирогч аливаа улс энэхүү протоколыг соёрхон батласан тухай батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн, батласан эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулахаар хүлээлгэн өгөхдөө эдгээр баримт бичгийг Сан байгуулах тухай 1971 оны конвенцид нэмэлт өөрчлөлт оруулсан 1992 оны протоколын 31 дүгээр зүйлд заасан зургаан сарын хугацаа дуусах хүртэл түр хүчингүй байна гэж энэ зүйлийн зорилгод нийцүүлэн зарлаж болно. Сан байгуулах тухай 1971 оны конвенцид нэмэлт өөрчлөлт оруулсан 1992 оны протоколыг соёрхон батласан тухай батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн, батласан, нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулсан улс энэ хэсгийн дагуу дээрхийн адил зарлаж болно.

3. Өмнөх хэсгийн дагуу зарласан аливаа улс нь Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдсэнээр тийнхүү зарласнаа хэдийд ч хүчингүй болгож болно. Ийнхүү хүчингүй болгох тухай мэдэгдэл нь энэхүү протоколыг соёрхон батласан тухай батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн, батласан, нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулсны дараа мэдэгдэл хүлээн авсан өдрөөс эхлэн хүчинтэй болно.

4. Соёрхон батласан тухай батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн батласан эсхүл нэгдэн орсон тухай холбогдох баримт бичгийг 1 дэх хэсэгт заасан хүчин төгөлдөр болох нөхцөл бүрдсэний дараа хадгалуулсан улсын хувьд, энэхүү протокол нь хадгалуулахаар хүлээлгэн өгсөн өдрөөс хойш арван хоёр сарын дараа хүчин төгөлдөр болно.

## 14 дүгээр зүйл

### Хянан өөрчлөх болон нэмэлт өөрчлөлт оруулах

1. Байгууллага нь Хариуцлагын тухай 1992 оны конвенцийг хянан өөрчлөх болон түүнд нэмэлт

өөрчлөлт оруулах зорилгоор бага хурал зарлан хуралдуулж болно.

2. Байгууллага нь Хариуцлагын тухай 1992 оны конвенцийг хянан өөрчлөх болон түүнд нэмэлт өөрчлөлт оруулах зорилгоор бага хурлыг доод тал нь хэлэлцэн тохирогч улсын гуравны нэгийн гаргасан хүсэлтээр зарлан хуралдуулна.

## 15 дугаар зүйл

### Хязгаарын хэмжээнд оруулах нэмэлт өөрчлөлт

1. Ерөнхий нарийн бичгийн дарга энэхүү протоколоор нэмэлт өөрчлөлт оруулсан Хариуцлагын тухай 1969 оны конвенцийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хариуцлагын хязгаарт нэмэлт өөрчлөлт оруулах тухай доод тал нь хэлэлцэн тохирогч талын дөрөвний нэгийн гаргасан хүсэлтийг Байгууллагын гишүүд болон хэлэлцэн тохирогч бүх талуудад хүргэнэ.

2. Дээрхийн дагуу хүргэсэн нэмэлт өөрчлөлт оруулах тухай саналыг хүргүүлэхээр илгээсэн өдрөөс хойш доод тал нь зургаан сарын дараа Эрх зүйн хороонд хэлэлцүүлэхээр хүргэнэ.

3. Энэхүү протоколоор нэмэлт өөрчлөлт оруулсан Хариуцлагын тухай 1969 оны конвенцийн хэлэлцэн тохирогч аливаа улс Байгууллагын гишүүн эсэхээс үл хамааран нэмэлт өөрчлөлтийг хэлэлцэн болон батлах тухай Эрх зүйн хорооны үйл ажиллагаанд оролцох эрхтэй.

4. Нэмэлт өөрчлөлтийг 3 дахь хэсгийн заалтаар өргөжүүлсэн бүрэлдхүүнтэй болсон Эрх зүйн хорооны санал хураалтанд оролцсон хэлэлцэн тохирогч талын гуравны хоёрын олонхиор батлана. Чингэхдээ санал хураалтанд хэлэлцэн тохирогч улсуудын хоёрын нэгээс доошгүй хувь нь оролцсон байна.

5. Хариуцлагын хязгаарт нэмэлт өөрчлөлт оруулах тухай саналыг хэлэлцэхдээ Эрх зүйн хороо өмнөх зөрчлийн туршлага, ялангуяа учруулсан хохирлын хэмжээ, мөнгөний ханшны өөрчлөлт болон даатгалын зардалд нэмэлт өөрчлөлтөөс үзүүлэх нөлөөлөл зэргийг харгалзан үзнэ. Үүнээс гадна энэхүү протоколоор нэмэлт өөрчлөлт оруулсан Хариуцлагын тухай конвенцийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хязгаар ба Газрын тосоор далайг бохирдуулахад учирсан хохирлыг нөхөн арилгах олон улсын сан байгуулах тухай 1992 оны олон улсын конвенцийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан хязгаар хоорондын харьцааг харгалзан үзнэ.

6 (а) Хариуцлагын хязгаарт энэ зүйлийн дагуу оруулах аливаа нэмэлт өөрчлөлтийг 1998 оны 1 дүгээр сарын 15-ны өдрөөс өмнө эсхүл энэ зүйлийн дагуу оруулсан өмнөх нэмэлт өөрчлөлт хүчин төгөлдөр болсноос хойш таваас доошгүй жилийн хугацаа өнгөрөөгүй бол хэлэлцэн үзэж үл болно. Энэ зүйлийн дагуу оруулах аливаа нэмэлт өөрчлөлтийг энэхүү протокол хүчин төгөлдөр болохоос өмнө хэлэлцэж үл болно.

(b) Хязгаарыг 1993 оны 1 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн жил бүр 6 хувиар нэмэгдэж, нийлмэл хувиар тооцогддог, энэхүү протоколоор нэмэлт өөрчлөлт оруулсан Хариуцлагын тухай 1969 оны конвенцид заасан хязгаарын хэмжээнээс илүү нэмэхгүй.

(c) Хязгаарыг энэхүү протоколоор нэмэлт өөрчлөлт оруулсан Хариуцлагын тухай 1969 оны конвенцид заасан хязгаарын хэмжээнээс 3 дахин их байхаар нэмэхгүй.

7. Байгууллага 4 дэх хэсгийн дагуу батласан аливаа нэмэлт өөрчлөлтийг хэлэлцэн тохирогч бүх улсад мэдэгдэнэ. Ийнхүү мэдэгдэл хийснээс хойш арван найман сарын дотор Эрх зүйн хороогоор нэмэлт өөрчлөлтийг батлах үед хэлэлцэн тохирогч тал байсан улсын дөрөвний нэгээс доошгүй нь нэмэлт өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөхгүй гэдгээ Байгууллагад мэдэгдэж, улмаар түүнийг буцааж, хүчингүй болгоогүй бол нэмэлт өөрчлөлт нь дурьдсан арван найман сарын дараа хүлээн зөвшөөрөгдсөн гэж тооцогдоно.

8. 7 дахь хэсгийн дагуу хүлээн зөвшөөрөгдсөнд тооцогдсон нэмэлт өөрчлөлт нь хүлээн зөвшөөрөгдсөнөөс хойш арван найман сарын дараа хүчин төгөлдөр болно.

9. Нэмэлт өөрчлөлт хүчин төгөлдөр болохоос доод тал нь зургаан сарын өмнө 16 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасны дагуу энэхүү протоколыг цуцлаагүй бол хэлэлцэн тохирогч бүх улс нэмэлт өөрчлөлтийн дагуу үүрэг хүлээнэ. Ийнхүү цуцлалт хийх нь нэмэлт өөрчлөлттэй нэгэн зэрэг хүчин төгөлдөр болно.

10. Нэмэлт өөрчлөлт Эрх зүйн хороогоор батлагдсан боловч түүнийг хүлээн зөвшөөрөх арван найман сарын хугацаа дуусаагүй үед аль нэгэн улс хэлэлцэн тохирогч тал болсон бол тухайн нэмэлт өөрчлөлтийг хүчин төгөлдөр болоход уг улс түүний дагуу үүрэг хүлээнэ. Арван найман сарын хугацаа дууссаны дараа хэлэлцэн тохирогч тал болсон аль нэгэн улс 7 дахь хэсгийн дагуу хүлээн зөвшөөрөгдсөн нэмэлт өөрчлөлтөөр үүрэг хүлээнэ. Энэ хэсэгт дурдсан дээрх тохиолдлуудад аль нэгэн улс нэмэлт өөрчлөлт хүчин төгөлдөр болоход эсхүл үүнээс оройтох бол энэхүү протокол хүчин төгөлдөр болоход нэмэлт өөрчлөлтийн заалтаар үүрэг хүлээнэ.

#### 16 дугаар зүйл

##### Цуцлалт

1. Оролцогч аль нэг тал өөрийнх нь хувьд хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш хэдийд ч энэхүү протоколыг цуцлаж болно.

2. Цуцлах тухай мэдэгдлийг Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулахаар хүлээлгэн өгч протоколыг цуцлана.

3. Цуцлах тухай мэдэгдлийг Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулахаар хүлээлгэн өгснөөс хойш арван сарын дараа, эсхүл мэдэгдэлд заасан хугацааны дараа цуцлалт хүчин төгөлдөр болно.

4. Энэхүү протоколд оролцогч талуудын хувьд аль нэг нь Хариуцлагын тухай 1969 оны конвенцийг түүний 16 дугаар зүйлийн дагуу цуцалсан бол энэхүү протоколоор нэмэлт өөрчлөлт оруулсан Хариуцлагын тухай 1969 оны конвенцийг мөн цуцалсан гэж тооцогүй.

5. Сан байгуулах тухай 1971 оны конвенцийн оролцогч улс тус конвенцид нэмэлт өөрчлөлт оруулсан 1992 оны протоколыг цуцалсан бол энэхүү протоколыг мөн цуцалсан гэж тооцно. Ийм цуцлалт нь Сан байгуулах тухай 1971 оны конвенцид нэмэлт өөрчлөлт оруулсан 1992 оны протоколын 34 дүгээр зүйлийн дагуу хийсэн цуцлалт хүчин төгөлдөр болох өдрөөс эхлэн үйлчилнэ.

#### 17 дугаар зүйл

##### Хадгалагч

1. Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга энэхүү протокол болон 15 дугаар зүйлийн дагуу хүлээн зөвшөөрөгдсөн аливаа нэмэлт өөрчлөлтийг хадгална.

2. Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга дараахь үүрэг хүлээнэ:

(a) энэхүү протоколд гарын үсэг зурсан эсхүл нэгдэн орсон бүх улсад дараахь зүйлийг мэдээлнэ:

(i) шинээр гарын үсэг зурсан эсхүл баримт хадгалуулахаар өгсөн тохиолдол бүрийн он, сар, өдөртэй нь;

(ii) 13 дугаар зүйлийн дагуу хийсэн аливаа мэдэгдэл болон Хариуцлагын тухай 1992 оны конвенцийн 5 дугаар зүйлийн 9 дэх хэсгийн дагуу хийсэн аливаа мэдэгдлийг;

(iii) Энэхүү протокол хүчин төгөлдөр болох өдрийг;

(iv) 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн дагуу хариуцлагын хязгаарт нэмэлт өөрчлөлт оруулах саналыг;

(v) 15 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн дагуу батласан аливаа нэмэлт өөрчлөлтийг;

(vi) 15 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн дагуу хүлээн зөвшөөрөгдсөнд тооцогдох аливаа нэмэлт өөрчлөлт болон 15 дугаар зүйлийн 8, 9 дэх хэсгийн дагуу түүний хүчин төгөлдөр болох өдрийг;

(vii) Энэхүү протоколыг цуцлах тухай мэдэгдэл болон түүнийг хүлээн авсан ба хүчин төгөлдөр болох өдрийг;

(viii) 16 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн дагуу хийсэн гэж тооцогдох цуцлалтыг;

(ix) Энэхүү протоколын аль нэг зүйлийн дагуу хийсэн аливаа мэдээллийг;

(b) энэхүү протоколын баталгаатай хуулбарыг түүнд гарын үсэг зурсан болон нэгдэн орсон бүх улсад хүргэнэ.

3. Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн 102 дугаар зүйлд заасны дагуу бүртгүүлэх, хэвлэн нийтлүүлэх зорилгоор Ерөнхий нарийн бичгийн дарга энэхүү протоколыг хүчин төгөлдөр болмогч Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга нарын газарт түүний эх бичвэрийг хүргэнэ.



18 дугаар зүйл

**Хэл**

Энэхүү протоколыг англи, араб, испани, орос, франц, хятад хэлээр тус бүр нэг хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй байна.

Нэг мянга есөн зуун ерэн хоёр оны арван

нэгдүгээр сарын хорин хоёрны өдөр Лондон хотноо үйлдэв.

Хэмээснийг нотлон тус тусын Засгийн газраас зохих ёсны дагуу эрхийг нь олгосон дор гарын үсэг зурагчид энэхүү протоколд гарын үсэг зурцгаав.

### ХАВСРАЛТ

#### ГАЗРЫН ТОСНЫ БОХИРДЛООС УЧРУУЛСАН ХОХИРЛЫН ДАГУУ ХҮЛЭЭХ ИРГЭНИЙ ХАРИУЦЛАГЫН ДААТГАЛ БОЛОН САНХҮҮГИЙН БУСАД БАТАЛГААНЫ ГЭРЧИЛГЭЭ

"Далайд газрын тос тээвэрлэгч хөлөг онгоцноос далайд учруулсан хохирлын талаар хүлээх

иргэний хариуцлагын тухай" 1992 оны олон улсын конвенцийн 7 дугаар зүйлийн заалтын дагуу олгов.

Хөлөг онгоцны нэр	Тоо болон үсгээр илэрхийлэгдсэн ялгаж тэмдэг	Бүртгэсэн боомт	Хөлөг онгоц эзэмшигчийн нэр, хаяг

Дээрх нэр бүхий хөлөг онгоцны хувьд "Далайд газрын тос тээвэрлэгч хөлөг онгоцноос далайд учруулсан хохирлын талаар хүлээх иргэний хариуцлагын тухай" 1992 оны олон улсын конвенцийн 7 дугаар зүйлийн дагуу тавих шаардлагад нийцсэн даатгал болон санхүүгийн бусад баталгааны гэрчилгээ нь хүчин төгөлдөр болохыг үүгээр нотлов.

ын Засгийн газар олгож эсхүл баталгаажуулав.

Олгосон газар .....  
.....-ны өдөр олгов.

Санхүүгийн баталгааны төрөл

Гэрчилгээ олгосон эсхүл баталгаажуулсан  
Хүний албан тушаал, гарын үсэг

Тайлбар:

Баталгаа хүчинтэй байх хугацаа

1. Шаардлагатай гэж үзвэл улсын бүтэн нэрийн мөрөнд гэрчилгээг олгосон эрх бүхий байгууллагын нэрийг оруулж бичиж болно.

Даатгагч болон/эсхүл баталгаа гаргагчийн нэр, хаяг:

2. Хэрэв гаргаж байгаа баталгааны нийлбэр дүн хэд хэдэн эх үүсвэрээс бүрдэж байгаа бол эх үүсвэр тус бүрийн бүрдүүлсэн хэмжээг зааж бичнэ.

Нэр

3. Олон төрлийн баталгаа гаргаж байгаа бол тэдгээрийг дугаарлаж бичнэ.

Хаяг

4. "Баталгаа хүчинтэй байх хугацаа" гэсэн мөрөнд баталгаа хүчин төгөлдөр болох огноог зааж бичих ёстой.

Энэхүү гэрчилгээ нь ..... хүртэл хүчинтэй.

(Улсын бүтэн нэр)

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.  
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> агентлагийн зөвлөл

Улсын Их Хурлын Тамгын газрын  
Хөлөөх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12  
Төрийн ордон

☎ 265958  
Индекс 14003

☎ 329487  
Хэвлэлийн хуудас 2.5